

## МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ ТҮҮВЭР СУДАЛГАА

*Н.АМАР, М.БОЛОР, Г.АРИУНХИШИГ, Н.БАТСАЙХАН*

### 1. Оршил

Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар МУИС-ийн Социологийн тэнхимтэй хамтран Монгол Улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтийн дунд 2003 оны 6-р сард санал асуулга явуулж, өмнөх оны (2002) мөн үеийнхээс хэр өөрчлөгдсөнийг харьцуулан дүн шинжилгээ хийж та бүхэнд толилуулж байна. Энэ жилийн судалгааны ажлын онцлог бол өмнөх оны суурь дээр тулгуурлан иргэдийн санал бодол өнгөрсөн оныхоос хэр өөрчлөгдсөнийг харуулахын зэрэгцээ судалгаанд оролцсон иргэдийг аймаг хот, нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлт, намын гишүүнчлэлийн байдлаар нь ангилан тус бүрээр нь тайлбар хийсэнд оршино.

Тайлант оны 10 дугаар сарын байдлаар мөнгөний нийлүүлэлтийн (M2) хэмжээ 623.4 тэрбум төгрөг; инфляцийн түвшин оны эхнээс 2.3 хувь, сүүлийн 12 сарын байдлаар 5.6 хувь; эдийн засагт оруулж буй санхүүгийн салбарын (банк болон банк бус санхүүгийн байгууллагууд) зээлжүүлэлтийн хэмжээ 430.0 орчим тэрбум төгрөг; иргэдийн хадгаламжийн хэмжээ 318.3 тэрбум төгрөг; улсын нэгдсэн төсвийн алдагдал 33.8 тэрбум төгрөг; улсын гадаад цэвэр албан нөөц 268.9 сая америк доллар; гадаад худалдааны алдагдал 208.7 сая америк доллар байна. Дээрх үзүүлэлтүүдийг 2002 оны 10 дугаар сарын тоон мэдээтэй харьцуулбал мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ 41.8 хувь, иргэдийн хадгаламжийн хэмжээ 71.7 хувь, гадаад худалдааны алдагдал 52.1 хувиар тус бүр өсчээ.

Олон улсын статистикийн лавлахууд дээр гарсан тоон үзүүлэлтүүдээс харахад: 1998 оны байдлаар Монгол улсын хүн амын 35.6 хувь нь ядуурлын түвшинд (Key indicators 2002, ADB); Хүний хөгжлийн түвшинг харуулсан индекс 2000 оны байдлаар 0.655, түүний зэрэглэлээр дэлхийн 173 улсуудын 113-т (Human development report 2002, UNDP); 2002 оны ДНБ-ий өсөлт 3.9 хувь, хэмжээ нь оны үнээр 1094.5 сая ам. доллар, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 443.1 ам. доллар; төсвийн алдагдал ДНБ-ий 5.7 хувь; гадаад худалдааны алдагдал ДНБ-ий 15.2 хувь; гадаадын шууд хөрөнгө оруулалт 63.0 сая ам. доллар (2002); гадаад өрийн хэмжээ 2002 оны эцсийн байдлаар 848.2 сая ам. долларт хүрч ДНБ-ий 80.7 хувийг эзэлж байна.

Энэ судалгааны ажлыг анх 2002 онд зохион байгуулсан бөгөөд зохих үр дүнгээ өгч олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдан танилцуулагдсан болно. Энэ жилийн хувьд асуултууд нь арай оновчтой болохын зэрэгцээ өнгөрсөн оныхтой харьцуулах боломжтой боллоо. Манай улсын хувьд зах зээлийн системд шилжин орсноос хойш олон шинэ дэвшилтэт амжилтууд гарч байгаа хэдий ч хүн амын ядуурал буурахгүй байгаа, бодит орлого бага, төсвийн алдагдал олигтой буурахгүй, ДНБ-ий өсөлт сул, гадаад өрийн хэмжээ өндөр байгаа нь сэтгэл зовоосон асуудал хэвээр байна. Дээр дурьдсан ололт амжилт болон хүндрэл бэрхшээлүүдийн талаар иргэдийн санал бодлыг сонсох нь цаашид ололтоо яаж бататгах, бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэхэд тус дөхөм болно гэдэгт эргэлзэхгүй байна. Иймээс Монголбанкны удирдлагын зүгээс нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлуудаар иргэдийн дунд санал асуулга явуулж, нэгтгэн дүгнэн, цаашдын бодлогын болон авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаандаа ашиглахаар шийдвэрлэж байна.

## **2. Судалгааны ажлын үндсэн зорилт**

### *2.1. Судалгааны ажлын зорилго*

Судалгааны ажлын зорилго нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн ерөнхий байдал, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн ашиглалт, татварын тогтолцоо болон ачаалал, банк санхүүгийн салбарын хөгжил, түүнээс хадгаламж, зээлийн талаар жирийн иргэдийн дунд товч санал асуулга явуулж нэгтгэн дүгнэж өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахын зэрэгцээ төсвийн бодлого, гаалийн байгууллагын үйл ажиллагаа, манай улсын эдийн засгийн хамгийн гол салбарын нэг хөдөө аж ахуйн салбарыг яаж хөгжүүлэх тал дээр товч асуулга явуулсан болно. Мөн судалгаанд оролцсон иргэдийг нас, хүйс, харьяалал, боловсрол, ажил эрхлэлт, намын гишүүнчлэлийн байдлаар бүлэглэн дүнг тус бүрээр нь задлан дэлгэрүүлэхийг зорилоо.

### *2.2. Судалгааны ажлын хамрах хүрээ, хугацаа*

Түүвэр судалгааг манай улсын эдийн засгийн том төвүүд болон орон нутгийн дийлэнхийг хамруулан 2003 оны 6 дугаар сарын 4-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Архангай, Булган, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудад явуулав. Санал асуулгыг тусгай баталсан удирдамжийн дагуу МУИС-ийн социологийн тэнхим, Монголбанк гэсэн 2 багт хуваагдан дээрх хот, аймгуудад хийж гүйцэтгэлээ.

### *2.3. Судалгааны ажлын мэдээллийн сан*

Энэ жилийн судалгаанд нийт 5281 иргэд оролцсон нь өмнөх оныхоос 2404 хүнээр их буюу 45.5 хувиар өссөн байна. Үүний 15.1 хувь нь Улаанбаатар хотын, 6 хувь нь Өвөрхангай, тус бүр 5.9 хувь нь Булган, Сүхбаатар, Ховд, Хэнтий, тус бүр 5.8 хувь нь Завхан, Хөвсгөл, тус бүр 5.7 хувь нь Говь-Алтай, Увс, Дархан-Уул, Орхон, тус бүр 5.6 хувь нь Архангай, Өмнөговь, 4.5 хувь нь Дорноговь аймгуудын оршин суугч нар байв. Үүнээс харахад судалгаанд хамрагдсан аймгуудаас (Улаанбаатар хотоос бусад) бараг жигд асуулга авч чадсан байна. Өнгөрсөн онд нийт 11 хот аймгуудаас санал асуулга авч байсан бол энэ онд 5 -аар их буюу 16 хот, аймгуудаас санал асуулга авч хүрээгээ тэлж чадсан байна. Түүний зэрэгцээ аймгийн төвүүдээс алслагдсан зарим сумдаар явж судалгаа явуулсан нь энэ жилийн бас нэг онцлог болно. Хүснэгт 1-с харахад Монгол улсын хүн амын

гуравны нэг гаруй нь оршин суудаг нийслэл хотоос хамгийн их, Дорноговь аймгаас хамгийн бага харин бусад аймгуудын хувьд ойролцоо жигд түвшинд оролцсон байна.

**Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо, хот аймгуудаар**

Судалгаанд хамрагдсан хот, аймгууд	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	Хувийн жин %
Архангай	298	5.6%
Булган	309	5.9%
Говь-Алтай	300	5.7%
Дорноговь	237	4.5%
Завхан	304	5.8%
Өвөрхангай	318	6.0%
Өмнөговь	297	5.6%
Сүхбаатар	309	5.9%
Сэлэнгэ	275	5.2%
Увс	299	5.7%
Ховд	314	5.9%
Хөвсгөл	308	5.8%
Хэнтий	314	5.9%
Дархан-Уул	299	5.7%
Улаанбаатар	797	15.1%
Орхон	303	5.7%
Бүгд	5281	100%

Судалгаанд оролцсон иргэдийн 43.1 хувь нь эрэгтэй, 56.9 хувь нь эмэгтэй байсан нь өмнөх оныхоос эмэгтэйчүүдийн тоо 3.6 нэгжээр өсчээ. Насны байдлаар нь авч үзвэл 17.9 хувь нь 25-аас доош, 29.1 хувь нь 25-34, 28.9 хувь нь 35-44, 17.2 хувь нь 45-54, 5.2 хувь нь 55-64, 1.6 хувь нь 65-аас дээш гэсэн насны ангилалд хамрагдаж байна. Үүнээс үзэхэд санал асуулгад 25-44 насны иргэд идэвхтэй оролцсон байна. Өнгөрсөн оныхоос 55-64 насныхны идэвх (1.8 нэгж) буурсан бол 45-54 насныхных (1.6 нэгж) өссөн байна.

Боловсролын түвшингээр ангилвал 13.1 хувь нь бүрэн бус дунд, 27.7 хувь нь бүрэн дунд, 18.2 хувь нь тусгай дунд, 40.9 хувь нь дээд боловсролтой байлаа. Дээрхээс харахад дээд боловсролтой иргэд хамгийн их оролцож санал бодлоо тусгасан байна. Өнгөрсөн онтой харьцуулахад бүрэн дунд (3.0 хувиар), тусгай дунд (2.2 хувиар) боловсролтой иргэдийн идэвх суларсан бол дээд боловсролтой иргэдийн идэвх (5.8 хувиар) дээшилсэн байна.

Судалгаанд оролцсон иргэдийн 56.7 хувь нь улсын болон хувийн байгууллагад ажилладаг, 20.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 15.9 хувь нь ажилгүй гэсэн ангилалд багтаж байна. Улсын болон хувийн байгууллагад ажилладаг иргэд маань илүү идэвхтэй оролцсон нь санал асуулгын дүнгээс харагдаж байна. Хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ажилгүй болон бусад гэсэн ангилалд хамрагдсан иргэдийн хувийн жин өнгөрсөн оныхоос буурсан бол улсын болон хувийн байгууллагад ажилладаг иргэдийнх эрс (9.7) өсчээ.

Судалгаанд оролцсон иргэдийг намын гишүүнчлэлээр ангилбал 26.1 хувь нь МАХН-ын, 15 хувь нь Ардчилсан намын, 26.7 хувь бусад намын гишүүд, 32.1 хувь нам бус иргэд байв. Намын харьяалалгүй иргэд санал асуулгад илүү их хамрагдсан байна.

Нийтэд нь дүгнэж хэлэхэд энэхүү судалгаанд дээд боловсролтой, улсын болон хувийн байгууллагад ажилладаг, 25-45 насны, эмэгтэй, нам бус иргэд түлхүү оролцсон байна.

**Хүснэгт 2. Судалгаанд оролцсон иргэдийн талаархи мэдээлэл**

		Хүйс		Нас		Боловсрол		Ажил эрхлэлт		Намын гишүүнчлэл	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	Тоо	Хувь
Хүйс	эр эм	2278 3003	43.1% 56.9%								
Нас	25 доош			945	17.9%						
	25-34			1539	29.1%						
	35-44			1526	28.9%						
	45-54			910	17.2%						
	55-64			277	5.2%						
	65 дээш			84	1.6%						
Боловсрол	бүрэн бус дунд					691	13.1%				
	бүрэн дунд					1465	27.7%				
	тусгай дунд					960	18.2%				
	дээд					2162	40.9%				
Ажил эрхлэлт	улсын хувийн ХХЭрхэлдэг ажилгүй бусад							1906	36.1%		
								1088	20.6%		
								1072	20.3%		
								840	15.9%		
								375	7.1%		
Намын гишүүнчлэл	МАХН Ардчилсан нам Бусад Нам бус									1379	26.1%
										790	15.0%
										1410	26.7%
										1697	32.1%
Хариулаагүй		0	0.0%	0	0.0%	3	0.1%	0	0.0%	5	0.1%
Нийт		5281	100.0%	5281	100.0%	5281	100.0%	5281	100.0%	5281	100.0%

*2.4. Судалгааны ажлын бүтэц, аргачлал*

Судалгааны ажил нь оршил, үндсэн зорилт, үр дүн, дүгнэлт гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрдэхээс гадна хавсралт I-VII зэргийг агуулсан болно. Нэгдүгээр хэсэг буюу оршил хэсэгт Монгол улсын нийгэм эдийн засгийн сүүлийн үеийн байдлыг товч дурьдсан; хоёрдугаар хэсэг буюу үндсэн хэсэгт судалгааны ажлын зорилго, хамрах хүрээ, мэдээллийн сан, бүтэц болон аргачлалын талаар дэлгэрэнгүй тайлбарласан; гуравдугаар хэсэг буюу энэ ажлын хамгийн чухал хэсэгт санал асуулгын ерөнхий дүнг нэгтгэн өмнөх онтой харьцуулан дүгнэлээ. Ингэхдээ санал асуулгад тусгагдсан 38 асуултыг утга агуулгаар нь ангилан 8 дэд бүлэг болгож, нийгэм, эдийн засгийн бодит байдалтай харьцуулан асуулт бүрээр дэлгэрэнгүй тайлбар өгөв. Тухайлбал:

1. Эдийн засгийн ерөнхий асуудлууд,
2. Нийгмийн тулгамдсан асуудлууд,
3. Гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж,
4. Татварын талаар,
5. Банк санхүүгийн салбарын тулгамдсан асуудлууд,
6. Хадгаламж, хуримтлал,
7. Зээлийн талаар,
8. Бусад (төсвийн бодлого, гаалийн үйл ажиллагаа, ХАА, г.м.).

Дөрөвдүгээр хэсэг буюу сүүлийн хэсэгт дээр дурдсан 8 дэд бүлгийг тус бүрээр нь нэгтгэн дүгнэж, цаашид авах арга хэмжээ, сургамжуудын талаар өгүүлсэн болно. Хавсралт I-VI-д судалгаанд хамрагдсан иргэдийг орон нутгийн харьяалал, хүйс, нас, боловсролын түвшин, ажил эрхлэлт, намын гишүүнчлэлийн байдлаар 6

хэсэгт бүлэглэн, бүлэг тус бүрээр нь тайлбарлан дүгнэлээ. Сүүлийн хавсралтанд (VII) иргэдийн хариултыг хүснэгтэнд тоон үзүүлэлтээр болон хувьчлан тусгав.

Санал асуулгад оролцсон иргэдийн цөөн хувь нь зарим асуултанд хариулаагүй учир асуулт бүр 100 хувийн хариулт авч чадаагүй болно. Мөн зарим асуултууд давхардсан хариулттай байсан учир нийт хариулт нь 100 хувиас илүү гарсан тохиолдлууд бий.

### 3. Судалгааны ажлын үр дүн

Тухайн улсын нийгмийн байдал, эдийн засгийн хөгжлийг тодорхойлдог олон үзүүлэлтүүд байдаг. Эдгээрийн дотор дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) өсөлт, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, хэрэглээний барааны үнийн өөрчлөлт (инфляци), гадаад худалдааны тэнцэл, банк санхүүгийн салбарын хөгжил, үндэсний валютын тогтвортой байдал, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн урсгал, гадаад өр, төсвийн алдагдал болон ажилгүйдэл, ядуурлын түвшин, татварын тогтолцоо зэрэг олон үзүүлэлтүүд гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тухайн улсын дүр төрхийг харуулдаг байна. Энэ санал асуулга нь манай улсын нийгэм, эдийн засгийн байдал, түүний дотор банк санхүүгийн салбар зах зээлийн системд шилжиж орсноос хойш өнөөг хүртэл хэрхэн өөрчлөгдсөн, одоо ямар байдалд байгааг жирийн иргэдийн зүгээс яаж дүгнэн цэгнэж байгааг харуулахын зэрэгцээ бодит байдалтай (статистикийн тоон үзүүлэлтүүдтэй) харьцуулан дүгнэхэд чиглэгдсэн юм. Түүний зэрэгцээ иргэдийн санал бодол жилийн дараа хэрхэн өөрчлөгдсөнийг харуулахыг зорилоо.

#### 3.1. Эдийн засгийн ерөнхий асуудлууд

Санал асуулгын ерөнхий асуулт (1.1.) буюу "Монгол улсын эдийн засгийн байдал таны бодлоор ямар байна вэ?" гэсэн асуултанд нийт оролцогчдын 37.9 хувь нь сайжирч байна, 34.8 хувь нь хэвэндээ гэж үзсэн бол 18.6 хувь нь муудаж байна, 8.7 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Энэ дүнг өнгөрсөн оныхтой харьцуулахад эдийн засгийн байдал сайжирч байна гэсэн үнэлгээ 4.1 хувиар өсч, нөгөө талаас муудаж байна гэсэн нь 4.3 хувиар буурсан байна.


#### 1.1. Монгол улсын эдийн засгийн байдал таны бодлоор

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Сайжирч байна	969	33.8%	2001	37.9%	4.1%
Муудаж байна	657	22.9%	984	18.6%	-4.3%
Хэвэндээ	1026	35.7%	1838	34.8%	-0.9%
Мэдэхгүй	218	7.6%	458	8.7%	1.1%
Нийт	2870	100.0%	5281	100.0%	0.0%
Хариулаагүй	7	0.2%	0	0.0%	-0.2%
Нийт	2877		5281		


Мөн судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 72.7 хувь нь манай улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал ямар ч гэсэн доройтож сулраагүй (хэвэндээ буюу сайжирч байна) сайжрах хандлагатай байна гэж үзсэн нь өнгөрсөн оныхоос 3.2 хувиар өсчээ. Харин 18.6 хувь нь эдийн засаг уналтанд орж байна гэж хариулсан нь тийм ч бага хувь биш юм. Энэ асуулт нь нийгэм эдийн засгийг хамарсан ерөнхий асуулт учраас бодит байдалтай харьцуулан тайлбарлахад их зүйл шаардагдана. Тиймээс маш товчхон хэдэн үгээр илэрхийлэхийг зорилоо. Түүний зэрэгцээ дээрх асуултын бүрэлдэхүүн хэсэг болох дэд асуултууд дараа тавигдах учраас давтахаас зайлсхийсэн болно. Монгол улсын эдийн засгийн байдал ямар

байна гэдгийг юуны түрүүнд эдийн засгийн өсөлтөөр тодорхойлж болох юм. Зураг 1-с харахад зах зээлийн системд шилжин орсон эхний жилүүдэд манай улсын эдийн засаг уналтанд орж өсөлт (ДНБ-ий өсөлт) нь сөрөг түвшинд байсан бөгөөд харин 1994 оноос эхлэн 2003 он хүртэл эерэг түвшинд байна. Хэдийгээр сүүлийн 9 жилийн турш эдийн засгийн өсөлт эерэг түвшинд байгаа ч 1990 оноос хойш нийт өсөлт 3.4 хувь, жилийн дундаж өсөлт 0.3 хувь, сүүлийн найман жилийн дундаж нь 3.2 байгаа нь зах зээлийн системд шилжин орж буй болон хөгжиж байгаа орнуудын хувьд сул үзүүлэлт юм. 2002 оны ДНБ-ий өсөлт 3.9 хувьтай гарсан нь өмнөх хоёр оны өсөлтөөс 2.8 нэгжээр илүү байгаа бөгөөд энэ нь цаашид эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх итгэлийг төрүүлж байна.

Зураг 1. ДНБ-ий өсөлт, хувиар



Зураг 2. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, ам. доллар



Эдийн засгийн өсөлттэй холбогдуулан бас нэг чухал үзүүлэлтийг авч үзье. Энэ бол нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ бөгөөд уг үзүүлэлт хэдий чинээ их байх тусам тухайн улсын эдийн засаг хөгжиж хүн амын бодит орлого өндөр байна гэсэн үг юм. Монгол улсын хувьд уг үзүүлэлт 1995-2002 онуудын дундажаар 419.9 ам. доллар, 2002 оны эцсийн байдлаар 442.2 ам. доллартай тэнцэж байгаа нь хүн амын бодит орлого багатай улсуудын тоонд багтаж байна (Зураг 2.). Учир нь 755 ам. доллараас багыг нь орлого багатай улсуудын тоонд хамруулдаг олон улсын жишиг байдаг. Уг үзүүлэлт нь 1995 онд дээд цэгтээ буюу 516.6 ам. долларт хүрч байсан бол 1996-1999 онуудад доошилж 363.6 ам. долларт хүрчээ. Харин 2000 оноос эхлэн тогтмол дээшилж байгаа нь цаашид тухайн үзүүлэлтэнд өсөлт гарах магадлалыг төрүүлж байна.

"Эдийн засгийн өсөлтийг хангахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?" гэсэн асуултанд (1.2.) судалгаанд оролцогчид нэгээс илүү хариултыг сонгосон бөгөөд нийт хариултын тоо нь 9318 болсон байна. Иргэдийн 29.7 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 25.1 хувь нь татварын хэмжээг бууруулах, 20.8 хувь нь зээлийн хүүг багасгах, 13.1 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, 9.3 хувь нь бизнесменүүддээ урамшуулал хөнгөлөлт үзүүлэх, 1.9 хувь нь бусад хүчин зүйлсээс хамаарч эдийн засаг өснө гэж хариулжээ.

### 1.2. Таны бодлоор эдийн засгийн өсөлтийг хангахын тулд

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Татварын хэмжээг бууруулах	1414	45.6%	2339	25.1%	-20.5%
ГХО-ыг нэмэгдүүлэх		0.0%	1224	13.1%	13.1%
Зээлийн хүүг багасгах	734	23.7%	1942	20.8%	-2.8%
Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих		0.0%	2770	29.7%	29.7%

Бизнесменүүдээ урамшуулах	731	23.6%	869	9.3%	-14.3%
Бусад	220	7.1%	174	1.9%	-5.2%
Нийт	3099	100.0%	9318	100.0%	0.0%
	-222	-7.7%	-4037	-76.4%	-68.7%
Нийт	2877		5281		

Өнгөрсөн оны асуултын хариултыг дэлгэрүүлэн хоёр шинэ хариулт (үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх) нэмсэн учир шууд харьцуулахад хүндрэл гарч байна. Тухайлбал, татварын хэмжээг бууруулах гэсэн хариулт өмнөх оныхоос 20.5 хувиар буурсан бол шинээр орсон үндэсний үйлдвэрлэлээ дэмжих гэсэн хариулт 30 орчим хувийн санал авсан байна. Бизнесменүүддээ хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх 14.3 хувиар буурсан бол гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх 13.1 хувийг эзэлж байна. Нэг талаас энэ бүхэн хоорондоо нарийн уялдаатай, нөгөө талаас бие биендээ сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай тул шинэ асуултуудыг нэмсэн нь иргэдийн санаа бодол, хариултын хүрээг улам задалж нарийсгасан байж болох юм. Ганц нэг жишээ дурьдвал, үндэсний үйлдвэрлэлээ дэмжихийн тулд татварын ачааллыг багасгаж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй болно, бизнесменүүддээ үзүүлж буй хөнгөлөлт, урамшуулал бол мөн л татварын хэмжээг бууруулах, гадаадын хөрөнгө орж ирэх орчныг нь бүрдүүлж өгөхтэй холбоотой юм. Иймээс санал асуулгад оролцсон иргэд маань энэ бүхнийг харгалзан хариулсан болов уу.

"Манай улсын ямар салбар эдийн засгийн өсөлтөнд их үүрэг гүйцэтгэх вэ?" гэсэн асуултанд (1.3.) судалгаанд оролцсон иргэд мөн нэгээс илүү хариулт өгсөн ба 19.7 хувь нь уул уурхай, 12.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 24.5 хувь нь хөдөө аж ахуй, 19.9 хувь нь аялал жуулчлал, 12.2 хувь нь банк санхүү, 8.9 хувь нь худалдаа үйлчилгээ, 2.7 хувь нь бусад салбар гэж хариулжээ.

### 1.3. Таны бодлоор ямар салбар эдийн засгийг түргэн хөгжүүлэх вэ ?

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Уул уурхай, олборлох	666	17.4%	1865	19.7%	2.3%
Боловсруулах	985	25.7%	1149	12.1%	-13.6%
Хөдөө аж ахуй	733	19.1%	2325	24.5%	5.4%
Аялал жуулчлал	608	15.9%	1889	19.9%	4.1%
Банк санхүү	383	10.0%	1156	12.2%	2.2%
Худалдаа үйлчилгээ	358	9.3%	841	8.9%	-0.5%
Бусад	98	2.6%	252	2.7%	0.1%
Нийт	3831	100.0%	9477	100.0%	0.0%
	-954	-33.2%	-4196	-79.5%	-46.3%
Нийт	2877		5281		

Эдийн засгийн салбаруудын өсөлт шинэ ангилал бий болсноос хойш ямар түвшинд байгаа, ДНБ-ий өсөлтөнд яаж нөлөөлж буйг дараахь хэдэн өгүүлбэрээр тайлбарлая. 1995 оноос 2002 хүртэл эдийн засгийн салбаруудын ДНБ-д эзлэх дундаж хувийг авч үзвэл: ХАА 34.9 хувь, худалдаа үйлчилгээ 19.8 хувь, уул уурхай, олборлох үйлдвэрлэл 13.0 хувь, боловсруулах үйлдвэрлэл 9.4 хувь, тээвэр холбоо 8.5 хувь, боловсрол 3.9 хувь, даатгал 2.9 хувь, эрүүл мэнд, халамж 2.6 хувь, цахилгаан дулаан 1.7 хувь, барилга 1.5 хувь, банк санхүү 1.2 хувь, бусад 1.6 хувийг тус тус эзэлж байна (Хүснэгт 3.). 1996 оноос хойш ХАА-н салбараас бусад салбарын дундаж өсөлт эерэг түвшинд байна. Хүснэгт 3.-аас харахад ДНБ-ий хамгийн их хувийг эзэлдэг ХАА-н салбарын үйлдвэрлэл 1996-1999 онуудад өссөн хэдий ч ган зуд гэх мэт байгалийн бэрхшээлүүдээс шалтгаалан сүүлийн жилүүдэд огцом уналтанд орж харин 2002 оны байдлаар уналтынх нь эрч саарсан байна.

Монгол улс бол хөдөө аж ахуйн орон. Иймээс энэ салбарын өсөлтийг дэмжихгүй бол эдийн засаг маань дорвитой өсөхгүй нь тодорхой. Өнгөрсөн онд судалгаанд оролцсон иргэдийн тавны нэг орчим хувь нь ХАА-н салбар эдийн засгийн өсөлтийг тодорхойлно гэж үзэж байсан бол энэ онд тэр хувь өсч дөрөвний нэг орчим хувь болжээ. Иймээс ХАА-н салбарт дорвитой өөрчлөлт хийх шаардлагатай байна. Ялангуяа мал аж ахуйг дан ганц байгалийн үзэгдлийн урсгалаар бус орчин үеийн эрчимжсэн фермерийн аж ахуйн хэлбэрээр өсгөх хэрэгтэй гэдгийг ойлгох цаг болжээ. Газар тариалангийн хувьд гадагш нь импортлодоггүй юм аа гэхэд дотоодын хэрэгцээгээ хангахуйц үйлдвэрлэл явуулж болно гэж үзэж байна. Дээр нь нэмж хэлэхэд ХАА-н бүтээгдэхүүний түүхий эдийн экспортын хэмжээг багасгаж дотооддоо боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг орчин үеийн технологийн үндсэн дээр бий болговол эдийн засгийн өсөлт хөгжилтөнд багагүй хувь нэмэр оруулах болно. ХАА-н салбарыг яаж хөгжүүлэх талаар санал асуулгын бусад гэсэн бүлэгт тусад нь асуулт тавьж тодруулсан болно.

### Хүснэгт 3. ДНБ-ий өсөлт, салбаруудаар

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	Дундаж	2002 оны хувийн жин
ДНБ	2.4%	4.0%	3.5%	3.2%	1.1%	1.0%	3.9%	2.7%	100.0%
ХАА	4.3%	4.3%	6.4%	4.2%	-14.9%	-18.5%	-10.5%	-3.5%	34.9%
Худалдаа, үйлчилгээ	0.3%	17.1%	-3.1%	1.3%	26.1%	9.8%	12.3%	9.1%	19.8%
Уул, уурхай, олборлох	6.1%	5.6%	4.9%	3.2%	6.6%	9.6%	-6.8%	4.2%	13.0%
Боловсруулах	-13.8%	-15.0%	3.2%	-2.8%	-3.3%	31.8%	22.1%	3.2%	9.4%
Тээвэр, холбоо	11.2%	5.8%	7.4%	6.1%	25.2%	14.9%	17.1%	12.5%	8.5%
Боловсрол	4.0%	4.1%	6.8%	4.6%	3.2%	1.3%	0.8%	3.5%	3.9%
Даатгал	0.3%	17.0%	-3.1%	1.2%	25.7%	8.0%	12.3%	8.8%	2.9%
Эрүүл мэнд, халамж	4.4%	3.0%	1.4%	3.1%	-0.1%	4.6%	2.9%	2.8%	2.6%
Цахилгаан, дулаан	0.7%	0.4%	3.2%	4.6%	0.4%	3.5%	4.0%	2.4%	1.7%
Барилга	2.6%	-2.7%	-1.1%	1.6%	-14.6%	10.8%	11.1%	1.1%	1.5%
Банк санхүү	42.2%	-26.7%	-33.0%	39.9%	7.0%	22.4%	7.8%	8.5%	1.2%
Бусад	5.7%	-0.9%	4.3%	2.1%	17.5%	0.9%	6.3%	5.1%	1.6%

Бөөний болон жижиглэн худалдаа нь ДНБ-ий 20 орчим хувийг (ХАА-н салбарын дараа) эзэлдэг бөгөөд санал асуулгад оролцсон иргэдийн 8.9 хувь нь эдийн засгийн өсөлтийг тодорхойлно гэж үзсэн нь өнгөрсөн оныхоос бага зэрэг буюу 0.5 хувиар буурсан байна. Энэ салбар нь 1996 оноос хойш дундаж өсөлтөөрөө тээвэр холбооны салбарын дараа хоёрт (9.1 хувь) байгаа бөгөөд иргэд маань энэ салбар эдийн засгийн өсөлтөнд багагүй хувь нэмэр оруулна гэж хариулсан хэвээр байна.

Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар нь ДНБ-ий 13.0 хувийг эзэлдэг бөгөөд 1996 оноос хойшхи жилийн дундаж өсөлт нь 4.2 хувьтай тэнцүү байна. Санал асуулгад оролцсон иргэдийн 19.7 хувь энэ салбар эдийн засгийн өсөлтийг хангана гэж хариулсан нь өмнөх оныхоос 2.3 хувиар илүү байна. 2002 оны сөрөг өсөлтийг (-6.8 хувь) эс тооцвол энэ салбарын өсөлт тогтмол эерэг хурдацтай байсан байна. (Хүснэгт 3.). Сүүлийн жилүүдэд манай нутаг дэвсгэр дээр геологийн том ордууд нээгдсэн нь уул уурхайн салбарын цаашдын өсөлтийг түргэсэх нь гарцаагүй.

Боловсруулах (хөнгөн) үйлдвэрлэл манай улсын эдийн засагт их үүрэг гүйцэтгэнэ гэж иргэдийн 12.1 хувь нь үзсэн нь өмнөх оныхоос 13.6 хувиар буурсан байна. Энэ нь нэг талаас өнгөрсөн онд бид хуучин ангиллаар аж үйлдвэр буюу хөнгөн үйлдвэрлэл гэж нэрлэсэн нь иргэдийг төөрөгдүүлсэн, нөгөө талаас зарим иргэдийн зүгээс эх орондоо хөнгөн үйлдвэрлэл явуулснаас түүхий эдээ гадагш нь шууд гаргаж импортын бараа хэрэглэсэн дээр гэж үзсэнтэй холбоотой байж

болох юм. Боловсруулах үйлдвэрлэл нь ДНБ-ий 9.4 хувийг эзэлдэг бөгөөд 1996 оноос 2002 хүртэлх жилийн дундаж өсөлт нь 3.2 хувь байна.

Банк санхүүгийн үйл ажиллагаа нь 1997-1998 оны банкны хямралын үед уналтанд орж байсан хэдий ч 1999 онд эргээд сэргэж, 1996 оноос хойшхи жилийн дундаж өсөлт нь 8.5 хувь байна. Санал асуулгад оролцогчдын 12.2 хувь нь банк санхүүгийн үйл ажиллагаа нь эдийн засгийн өсөлтөнд чухал үүрэг гүйцэтгэнэ гэсэн нь өнгөрсөн оныхоос 2.2 хувиар өсчээ. Банк санхүүгийн салбарын тогтвортой үйл ажиллагаа өргөжин тэлэх нь бусад салбаруудын өсөлт хөгжилтөнд эерэг үүрэг гүйцэтгэх болно.

Аялал жуучлалын салбарыг судалгаанд оролцсон иргэдийн 19.9 хувь нь эдийн засгийн өсөлт хөгжилтөнд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзсэн нь өнгөрсөн оныхоос 4.1 хувиар өсчээ. Энэ салбарын ирээдүйн хөгжлийг дэмжиж, таатай орчныг бий болгож чадвал багагүй хэмжээний хөрөнгө урсгал орж ирэх боломжтой юм.

Санал асуулгын хариултын хүрээнд хамрагдаагүй зарим салбаруудын талаар товчхон дурьвал: тээвэр, холбооны салбар нь ДНБ-ий 8.5 хувийг эзэлдэг бөгөөд 1996 оноос хойш жилийн дундаж өсөлтөөрөө тэргүүлж байгаа буюу 12.5 хувь, боловсролын салбар нь ДНБ-ий 3.9 хувь, дундаж өсөлт нь 3.5 хувь, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгалын салбар нь ДНБ-ий 2.9 хувийг эзэлж дундаж өсөлтөөрөө 8.8 хувь байна.

"Хэрэглээний барааны үнэ таны бодлоор" гэсэн асуултанд (1.4.) 44.8 хувь нь өсч, 5.2 хувь нь буурч, 42.2 хувь нь тогтворжиж, 7.8 хувь нь мэдэхгүй байна гэж хариулжээ.

#### 1.4. Өргөн хэрэглээний барааны үнэ таны бодлоор

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Өсч байна	1514	52.9%	2365	44.8%	-8.1%
Буурч байна	111	3.9%	276	5.2%	1.3%
Тогтворжиж байна	1235	43.2%	2226	42.2%	-1.0%
Мэдэхгүй			413	7.8%	7.8%
Нийт	2860	100.0%	5280	100.0%	0.0%
Хариулаагүй	17	0.6%	1	0.0%	-0.6%
Нийт	2877		5281		

Өнгөрсөн онтой харьцуулахад үнэ өсч байна, тогтворжиж байна гэсэн хариултууд тус тус 8.1, 1.0 хувиар буурсан бол буурч байна 1.3 хувиар нэмэгджээ. Энд нэг зүйлийг тодруулан хэлэхэд 2001 оны санал асуулгад мэдэхгүй гэдэг хариултыг оруулж өгөөгүй учир 2002 оны үнэ өсч байна гэсэн хариултын хувийг бууруулсан байж болох талтай юм. 1990 оноос эхлэн захиргаадалтын үнийг чөлөөлсний дараа үнийн өсөлт огцом явагдаж, 1994 оноос өсөлтийн хурд нь саарч, 1998 оноос эхлэн тогтворжин өдийг хүртэл нэг оронтой тоогоор илэрхийлэгдэж байна (Зураг. 4). Үнийн өсөлт бага, эерэг түвшинд, тогтвортой байна гэдэг эдийн засгийн өсөлт хөгжилт болон иргэдийн амьжиргааны түвшин дээшлэхэд их үүрэгтэй. Харин манай улсын зах зээл гадаад худалдаанаас ихээхэн хамааралтай тул дотоодын үнийн өөрчлөлт гадаад зах зээлийн үнийн өөрчлөлтөөс ихээхэн шалтгаалахыг үгүйсгэхгүй. Нэг л жишээ дурьдахад энэ онд гадаадаас импортлодог бензин шатахууны үнэ нэмэгдсэнээс болж зарим өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдсэн юм.

#### 3.2. Нийгмийн тулгамдсан асуудлууд

"Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд" гэсэн асуултанд 21.4 хувь нь дээшилсэн гэж хариулсан нь өнгөрсөн оныхоос 10.8 хувиар буурсан, 22.3 хувь нь доошилсон гэж үзсэн нь 3.5 хувиар нэмэгдсэн, 54.4 хувь нь хэвэндээ гэсэн нь 5.4 хувиар өссөн дүн гарчээ. Харин 1.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (2.1.). Энэ хариултаас харахад иргэдийн өрхийн амьжиргааны түвшин өнгөрсөн оныхоос доошилсон (3.5 хувь) мөн хэвэндээ буюу өөрчлөгдөөгүй (5.4 хувь) байна гэсэн дүгнэлт гарч байна. Эдийн засгийн байдал сайжирч байна гэж иргэд маань хариулсан мөртлөө өрхийнх нь амьжиргааны түвшин доошилж байна гэж хариулсан нь нэг талаас эдийн засагт бий болж буй өсөлтийн үр өгөөж олон хүнд тэгш хүртэхгүй байна гэсэн бодлыг төрүүлж байна. Түүнээс гадна өнгөрсөн онд санал асуулгад оролцсон иргэдийн 81.2 хувь нь амьжиргааны түвшин дордоогүй буюу дээшлэх хандлагатай байна гэж үзсэн байхад энэ жилийн хувьд 75.8 хувь болж 5.4 нэгжээр буурчээ. Үүний зэрэгцээ 22.3 хувь нь амьдрал хэцүү байна гэсэн нь 1998 оны байдлаар Монгол улсын хүн амын 35.6 хувь нь ядуурлын түвшинд байна (Key Indicator 2002, ADB) гэсэн дүгнэлтэнд дөхөж очиж байна.

### 2.1. Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Дээшилсэн	924	32.2%	1130	21.4%	-10.8%
Доошилсон	539	18.8%	1179	22.3%	3.5%
Хэвээрээ	1406	49.0%	2871	54.4%	5.4%
Мэдэхгүй		0.0%	100	1.9%	1.9%
Нийт	2869	100.0%	5280	100.0%	0.0%
Хариулаагүй	8	0.3%	1	0.0%	-0.3%
Нийт	2877		5281		

Зах зээлийн системд шилжин орсноос хойш манай улсад баян, ядуу, дунд зэргийн гэх мэтчилэн нийгмийн янз бүрийн давхаргууд (баян хоосны ялгаа) бий болж тэдний хоорондох ялгаа эрс харагдах болсон билээ. Өмнөх тогтолцооны үед нийгмийн баялгийг тэнцүү хуваах зарчимтай байсан нь шинэ тогтолцоо буюу зах зээлийн системд энэ бүхэн өөрчлөгдсөнийг та бүхэн мэдэж байгаа. Магадгүй иргэдийн зарим хэсэг нь хуучин сэтгэлгээгээсээ одоо хүртэл салаагүйг үгүйсгэхгүй.

Санал асуулгад хариулсан иргэдийн 66.6 хувь нь хүн амын ядуурал нэмэгдэж байна гэсэн нь өнгөрсөн оныхоос 1.8 хувиар, 10.2 хувь нь буурч байна гэсэн нь 2.2 хувиар, 18.0 хувь нь хэвэндээ байна гэсэн нь 1.3 хувиар тус тус буурчээ. Харин 5.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (2.2.). Хэдийгээр ядуурал нэмэгдэж байна гэсэн хариулт өнгөрсөн оныхоос бага зэрэг буурсан ч хувийн жин нь өндөр хэвээр байна.

### 2.2. Хүн амын ядуурал таны бодлоор

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдэж байна	1954	68.3%	3515	66.6%	-1.8%
Буурч байна	354	12.4%	539	10.2%	-2.2%
Хэвэндээ байна	551	19.3%	949	18.0%	-1.3%
Мэдэхгүй		0.0%	276	5.2%	5.2%
Нийт	2859	100.0%	5279	100.0%	0.0%
Хариулаагүй	18	0.6%	2	0.0%	-0.6%
Нийт	2877		5281		

Азийн Хөгжлийн банкнаас гаргадаг статистикийн лавлах дээр 1998 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын 35.6 хувь нь (хотод 39.4 хувь, хөдөө орон нутагт 32.6 хувь) ядуурлын түвшинд, 13.9 хувийнх нь орлого буюу хэрэглээ өдрийн нэг ам. доллараас доош түвшинд, эдийн засгийн орлогын 35.0 хувь нь тэгш бус хуваарилагддаг (Gini coefficient) гэж дурьджээ. Хүн амын гуравны нэг гаруй нь ядуурлын түвшинд байна гэдэг бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад тийм ч өндөр биш боловч ядуурлын түвшинд байна гэж ойлгож болно. Үүний ч нэг үндэслэл бол ОУВС-гаас 2000 оны 9 дүгээр сараас эхлэн "Ядуурлыг буруулах, өсөлтийг хангах" (PRGF) хөтөлбөрийг Монгол улсад хэрэгжүүлж эхлээд байна. Магадгүй уг хөтөлбөр амжилттай хэрэгжихийн зэрэгцээ иргэд маань өөрсдөө хувиараа хөдөлмөр эрхлэж ирээдүйн хуримтлалаа бага боловч бий болгож чадвал нийт хүн амын ядуурал буурах болно. Энэ үйлсэд төр засгийн оролцоо ч (татвар бууруулах, бодит орлогыг бүрдүүлэх суурийг тавьж өгөх, ажлын байрыг шинээр бий болгох, гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтыг зөв зохистой хуваарилах, г.м.) их үүрэг гүйцэтгэнэ.

"Ажилгүйчүүдийн тоо таны бодлоор" гэсэн асуултанд 69.0 хувь нь нэмэгдэж байна, 11.1 хувь нь буурч байна, 14.3 хувь нь хэвэндээ байна, 5.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (2.3.). Өнгөрсөн онтой харьцуулахад нэмэгдэж байна 2.7, буурч байна 1.0, хэвэндээ байна 1.8 хувиар тус тус буурчээ. Энэ нь нэг талаас өнгөрсөн оны санал асуулгад мэдэхгүй гэсэн хариултыг оруулаагүй учир бусад хариултуудын хувийг бууруулсан нөгөө талаас статистикийн тоон үзүүлэлтүүдийг харахад ажилгүйчүүдийн тоо багасаж байгаатай дөхсөн болов уу. ҮСГ-аас гаргадаг статистикийн мэдээллээс харахад (Зураг 3.) хөдөлмөр эрхлэлтийн албанд албан ёсоор бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 1990 онд 45.7 мянга, 1994 онд 74.9 мянга байсан бол 2002 онд 30.9 мянга болж буурчээ. Мөн Зураг 3-с харахад ажилгүйдлийн түвшин 1990 онд 5.5 хувь, 1994 онд 8.7 хувь байсан бол сүүлийн 3 жилд буурч 3.4 хувь болсон байна. Хэдийгээр ажилгүйчүүдийн тоо буурч байгаа, өнгөрсөн оныхоос өсч байна гэсэн хариултын хувь багассан ч хувийн жингээрээ өндөр хэвээр байна.



### 2.3. Ажилгүйчүүдийн тоо таны бодлоор

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдэж байна	2048	71.8%	3644	69.0%	-2.7%
Буурч байна	346	12.1%	587	11.1%	-1.0%
Хэвэндээ байна	459	16.1%	756	14.3%	-1.8%
Мэдэхгүй		0.0%	291	5.5%	5.5%
Нийт	2853	100.0%	5278	100.0%	0.0%
Хариулаагүй	24	0.8%	3	0.1%	-0.8%
Нийт	2877		5281		

Монгол улсад доноруудаас ажлын байрыг нэмэгдүүлэх олон төсөл хэрэгжиж байгаа, ажиллах хүчнээ гадаадад гаргаж байгаатай уялдан ажилгүйчүүдийн түвшин багасаж байна хэмээн статистикийн мэдээлэл дурьдаж байгаа хэдий ч судалгаанд оролцсон иргэдийн 70 орчим хувь нь ажилгүйчүүдийн тоо ихсэж байна гэж үзжээ.

Зураг 3. Ажилгүйчүүдийн тоо, түвшин

Зураг 4. Инфляцийн түвшин, жилийн эцсийн байдлаар



Судалгаанд оролцсон иргэдийн 55.9 хувь газар хувьчлалыг дэмжиж байна, 28.6 хувь нь дэмжихгүй байна, 15.5 хувь мэдэхгүй гэж хариулжээ (2.4.). Иргэдийн ихэнх нь газар хувьчлалыг дэмжиж, түүнийг чухал гэдгийг нь ойлгож эхэлж байгаа нь өнгөрсөн оныхоос дэмжиж байгаа нь 16.3 хувиар өсч, харин дэмжихгүй байгаа нь 14.7 хувиар буурснаар харагдаж байна.

#### 2.4. Газар хувьчлалыг

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Дэмжиж байна	1133	39.6%	2947	55.9%	16.3%
Дэмжихгүй байна	1239	43.3%	1508	28.6%	-14.7%
Мэдэхгүй	491	17.1%	820	15.5%	-1.6%
Нийт	2863	100.0%	5275	100.0%	0.0%
Хариулаагүй	14	0.5%	6	0.1%	-0.4%
Нийт	2877		5281		

Газрыг хувьчлах нь нэг талаас манай улсын иргэдийн хувьд үнэ төлбөргүй тодорхой хэмжээний хувийн өмчтэй болж түүнийгээ захиран зарцуулах эрхтэй болох, нөгөө талаас улсын мэдэлд байсан өмч хувьд очин тодорхой хариуцах эзэнтэй болж хараа хяналтанд орох зэрэг олон сайн талуудтай юм. Харин газрын байршил, үржил шимтэй эсэх болон бусад олон асуудлуудаас шалтгаалан хувьчлал дээр нь маргаантай асуудлууд ихээр гарч болзошгүйг анхаарах хэрэгтэй байна.

#### 2.5. Таны бодлоор газар хувьчлалын үйл ажиллагаа

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Зөв явж байна			1574	29.8%	
Буруу явж байна			1599	30.3%	
Мэдэхгүй			2100	39.8%	
Нийт			5273	100.0%	
Хариулаагүй			8	0.2%	
Нийт			5281		

Харин одоо газар хувьчлалын үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгааг тодруулъя. Энэ асуулт нь өнгөрсөн онд тавигдаагүй учир (газар хувьчлал эхлээгүй байсан) харьцуулалгүй шууд тайлбарласан болно. Зөв явагдаж байна гэж 29.8 хувь нь үзсэн байхад, буруу гэж 30.3 хувь нь, мэдэхгүй гэж 39.8 хувь нь хариулжээ. Энэ асуултанд иргэдийн санал ерөнхийдөө тэнцүү хуваагдсан байна (2.5.).

Монгол улсад үйлчилж буй даатгалын тогтолцоог иргэдийн 25.0 хувь нь үр дүн өгч байна, 38.1 хувь нь өгөхгүй байна, 36.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Эндээс харахад манай улсын даатгалын тогтолцооны үйл ажиллагаа иргэдийг хамруулж чадахгүй, нөгөө талаас иргэд ч идэвхтэй оролцохгүй эсвэл ойлгохгүй байгаа нь илэрхий байна. Ямарваа нэгэн даатгалд хамрагдах нь хувь хүний хэрэг боловч түүний үр дүн ач холбогдлын талаар иргэдэд сайтар ойлгуулах хэрэгтэй байна. Түүний зэрэгцээ даатгалын байгууллагууд маань үйл ажиллагаагаа сайжруулан тогтмолжуулж, сурталчилгаа сайн явуулахгүй юм бол энэ үйл ажиллагаа хөгжихгүй гэдгийг анхааралдаа авах цаг нь болжээ. Өнгөрсөн оныхтой харьцуулахад үр дүн өгч байна, өгөхгүй байна гэсэн хариултууд тус тус 5.0, 13.9 хувиар буурч, мэдэхгүй буюу идэвхгүй хариултын хувь хоёр дахин нэмэгджээ.

### 2.6. Даатгалын (эрүүл мэндийн даатгалын) тогтолцоо

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Үр дүн өгч байна	856	29.9%	1315	25.0%	-5.0%
Үр дүн өгөхгүй байна	1487	52.0%	2007	38.1%	-13.9%
Мэдэхгүй	516	18.0%	1945	36.9%	18.9%
Нийт	2859	100.0%	5267	100.0%	0.0%
Хариулаагүй	18	0.6%	14	0.3%	-0.4%
Нийт	2877		5281		

### 3.3. Гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж

Гадаадаас зээл тусламж авах, гадаадын хөрөнгө оруулалтыг түлхүү оруулах нь хөгжиж буй орнуудын нийгэм эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гагцхүү түүнийгээ хэрхэн зөв ашиглах, үр өгөөжийг нь яаж хүртэх, ирээдүйд өрийн дарамтанд орохгүй байх нь чухал юм. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн системээс зах зээлийн системд шилжсэн эхний жилүүдэд манай улсад зээл тусламж өгч, хөрөнгө оруулалт хийдэг байсан хуучин социалист орнуудын өөрсдийнх эдийн засгийн байдал хүнд байдалд орсон учир гадаадаас орж ирэх хөрөнгийн урсгал бараг зогсч зөвхөн хуучин системийн өв болох их өртэй үлдсэнийг хэн бүхэн мэдэх билээ. 1992 оны байдлаар манай улс 350.2 сая ам.долларын өртэй, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2.0 сая ам. доллар, гадаадын зээл тусламжийн хэмжээ 37.9 сая ам. доллар байсан бол 2002 оны эцсийн байдлаар гадаад өрийн хэмжээ 848.2 сая ам. доллар буюу ДНБ-ий 80.7 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалт 63.0 сая ам. доллар буюу ДНБ-ий 6.2 хувь, гадаадын зээл тусламжийн хэмжээ 87.4 сая ам. доллар буюу ДНБ-ий 8.3 хувьд хүрчээ (Зураг 5.6.).

Гадаадаас авч буй зээл тусламжийн ашиглалтын тухайд судалгаанд оролцогчдын 18.6 хувь нь сайн, 44.2 хувь нь хангалтгүй, 7.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (3.1.).

### 3.1. Гадаадаас авч буй зээл тусламжийн ашиглалт таны бодлоор

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Сайн байна	400	14.0%	980	18.6%	4.6%
Хангалтгүй байна	1620	56.5%	2331	44.2%	-12.4%
Мэдэхгүй	845	29.5%	1965	37.2%	7.8%
Нийт	2865	100.0%	5276	100.0%	0.0%

Хариулаагүй	12	0.4%	5	0.1%	-0.3%
Нийт	2877		5281		

Өнгөрсөн оныхтой харьцуулахад хангалтгүй гэж хариулсан нь 12.4 хувиар буурч, сайн байна, мэдэхгүй гэж хариулсан нь тус тус 4.6, 7.8 хувиар өсчээ. Иргэдийн ихэнх гадаадын зээл тусламжийн ашиглалтыг хангалтгүй ба мэдэхгүй гэж үзэж байгаа нь нэг талаас үр өгөөж нь иргэн бүрт хүрээгүй эсвэл тухайн хүн мэдрэхгүй байгаатай, нөгөө талаас гадаадын зээл тусламжийн ашиглалт зарцуулалт хангалтгүй, үр дүнг олон нийтэд ойлгуулан сурталчилж чадахгүй байгаатай холбоотой юм.


Гадаадын хөрөнгө орж ирэх орчныг бүрдүүлэх нь ашигтай гэж судалгаанд оролцогчдын 68.4 хувь нь, ашиггүй гэж 10.0 хувь нь, мэдэхгүй гэж 21.6 хувь нь үзжээ (3.2.). Өнгөрсөн оныхтой харьцуулахад ашигтай болон ашиггүй гэсэн хариултууд тус тус 2.3, 2.4 хувиар өсч, мэдэхгүй гэсэн хариулт 4.7 хувиар буурсан байна.

### 3.2. Гадаадын хөрөнгө орж ирэх орчныг бүрдүүлэх нь


	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Ашигтай	1890	66.1%	3607	68.4%	2.3%
Ашиггүй	218	7.6%	529	10.0%	2.4%
Мэдэхгүй	751	26.3%	1138	21.6%	-4.7%
Нийт	2859	100.0%	5274	100.0%	0.0%
Хариулаагүй	18	0.6%	7	0.1%	-0.5%
Нийт	2877		5281		

Иргэдийн дийлэнх олонхи нь гадаадын хөрөнгө орж ирэх орчныг бүрдүүлвэл илүү ашигтай гэж үзжээ. Энэ нь эдийн засгийн өсөлт хөгжилтөнд тус нэмэртэй, шинээр ажлын байр бий болно, гадаадын хөрөнгө оруулагчид бизнесийн эрсдэлээ ямар нэгэн хэмжээгээр өөрсдөө хариуцна гэдэгтэй холбоотой байж болох юм. 1992 оны байдлаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 2.0 сая ам. доллар буюу ДНБ-ий 0.4 хувьтай тэнцэж байсан бол 1997 онд 25.0 сая ам. доллар буюу ДНБ-ий 2.4 хувь, 2002 оны эцсийн байдлаар 77.8 сая ам. доллар буюу ДНБ-ий 7.1 хувь болж өссөн байна (Зураг.7). Өнгөрсөн онуудын байдлаас харахад аж үйлдвэр, худалдаа үйлчилгээ, барилга байгууламж, банк санхүү, харилцаа холбоо, тээвэр, аялал жуучлалын салбаруудад гадаадын хөрөнгө оруулалт түлхүү хийгджээ.

Зураг 5. Гадаадын тусламж, сая ам. доллар



Зураг 6. Гадаад өр, сая ам.доллар



Мэдээж Засгийн газрын оролцоотойгоор гадаадаас авсан зээлийг эргээд улс л төлж таарна, харин пүүс компани болон хувь хүмүүсийнхийг тэд өөрсдөө л төлнө. Авсан зээлээ үр өгөөжтэй ашиглаж, эх орныхоо эдийн засагт тус нэмэр оруулан,

цаг тухайд нь эргэн төлж байвал нэг их буруушаагаад байх зүйл биш юм. Засгийн газар маань гадаадаас зээл авах, дотоодын компани пүүсүүдэд зуучлахын оронд гадаадын хөрөнгө орж ирэх таатай орчныг бүрдүүлбэл илүү ашигтай байж болох юм.


Гадаадын байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслүүд таны хувьд гэсэн асуултанд иргэдийн 17.3 хувь хүртээмжтэй байна, 59.0 хувь нь хүртээмжгүй байна, 23.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (3.3.). Энэ асуулт өнгөрсөн оны санал асуулгад тусгагдаагүй учир харьцуулалгүй шууд тайлбарласан болно.

Монгол улсад өнөөгийн байдлаар Япон, ОХУ, Герман, БНСУ, Кувейт, Финлянд зэрэг арав гаруй улсын, АХБ, Дэлхийн банк, Нордикийн сан зэрэг хэд хэдэн олон улсын санхүүгийн байгууллагын 100 гаруй төслүүд хэрэгжиж байна. 2002 оны эцсийн байдлаар төслийн зээлийн нийт үлдэгдэл 780.8 сая америк доллар буюу ДНБ-ий 71.3 хувь, гадаадын өрийн 92.1 хувьтай тэнцүү байна. Манай улсад хэрэгжүүлж байгаа төслүүд ихэвчлэн зам харилцаа, дэд бүтэц, тусгай зориулттай тусламж, эрчим хүч, санхүүгийн салбар, хүнд үйлдвэрлэл, цахилгаан холбоо, хөдөө аж ахуй салбаруудад чиглэгддэг байна.


### 3.3. Гадаадын байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслүүд таны хувьд

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Хүртээмжтэй байна			914	17.3%	
Хүртээмжгүй байна			3113	59.0%	
Мэдэхгүй			1249	23.7%	
Нийт			5276	100.0%	
Хариулаагүй			5	0.1%	
Нийт			5281		

Зураг 7. Гадаадын хөрөнгө оруулалт, сая ам.доллар



Зураг 8. Татварын орлого (ачаалал), тэрбум төгрөг



### 3.4. Татварын талаар

Эдийн засгийн ерөнхий асуулгад татварын тухай дээр дурьдсаныг та бүхэн санаж байгаа байх. Судалгаанд хамрагдсан иргэдийн дөрөвний нэг нь татварын ачааллыг багасгавал эдийн засгийн өсөлтөнд зохих хувь нэмрээ оруулна гэж хариулсан байгаа. Одоо татварын ерөнхий түвшингийн талаар юу бодож байгааг сонирхоё (4.1.). Нийт иргэдийн маань 66.0 хувь нь өндөр гэж хариулсан нь өнгөрсөн оныхоос 1.5 нэгжээр, 23.3 хувь нь боломжийн гэсэн нь 2.6 нэгжээр тус тус өсч, 10.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь 4.0 нэгжээр буурчээ. Мөн татварын ачаалал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн гэж 73.3 хувь нь үзэж байхад хэвэндээ гэж 22.0 хувь, буурсан гэж 4.7 хувь нь хариулсан байна (4.2.). Өнгөрсөн

онтой харьцуулахад татварын ачаалал нэмэгдсэн гэж хариулсан нь 5.2 хувиар буурсан хэдий ч иргэдийн дийлэнх татварын ачаалал их байна гэж үзсэн хэвээр байна. Харин хэвэндээ буюу буурсан гэж хариулсан нь тус бүр 3.6, 1.6 нэгжээр өсчээ.

#### 4.1. Монгол улсад үйлчилж буй татварын ерөнхий түвшин таны бодлоор

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Өндөр	1844	64.5%	3483	66.0%	1.5%
Боломжийн	592	20.7%	1229	23.3%	2.6%
Мэдэхгүй	423	14.8%	569	10.8%	-4.0%
Нийт	2859	100.0%	5281	100.0%	0.0%
Хариулаагүй	18	0.6%	0	0.0%	-0.6%
Нийт	2877		5281		

Дээрх хариултуудаас харахад манай улсад үйлчилж буй татварын системийн өнөөгийн бодлого болон тогтолцооноос шалтгаалан татварын ерөнхий түвшин өндөр, ачаалал нь жил тутам ихсэж иргэдийн бодит орлогыг өсгөхгүй, бизнес хийхэд нь саад болж улмаар эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлж болохоор байна гэж санал асуулгад оролцсон иргэдийн ихэнх нь дүгнэжээ.

#### 4.2. Татварын ачаалал сүүлийн жилүүдэд

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдсэн	2226	78.5%	3476	73.3%	-5.2%
Хэвэндээ	520	18.3%	1042	22.0%	3.6%
Буурсан	88	3.1%	221	4.7%	1.6%
Мэдэхгүй	0	0.0%	0	0.0%	0.0%
Нийт	2834	100.0%	4739	100.0%	0.0%
Хариулаагүй	43	1.5%	542	10.3%	8.8%
Нийт	2877		5281		

Зураг 8-аас харахад зах зээлийн системд шилжсэн эхний жилүүдэд татварын ачаалал нь (ДНБ-д эзлэх хувийн жингээр) өндөр, хэлбэлзэл нь их байсан бол 1994-1999 онуудад бага зэрэг буурч ойролцоогоор 20 орчим хувьд тогтвортой байсан байна. Харин 2000 оноос эхлэн татварын ачаалал огцом нэмэгдэж, 2002 онд дээд цэгтээ буюу 29.0 хувь болж өсчээ. Эндээс дүгнэж хэлэхэд татварын ерөнхий түвшин өндөр, сүүлийн жилүүдэд ачаалал нь нэмэгдсэн гэсэн иргэдийн дүгнэлттэй бодит байдал тохирч байна.

Энэ хэсэгт бас нэг чухал зүйлийг хэлэхэд татварын түвшин өндөр, ачаалал их байгаа үед татвараас зайлсхийх явдал нийтлэг байна гэж хариулсан иргэдийн 67.7 хувь үзсэн нь үүний нэг баталгаа болов уу. Харин 12.9 хувь нь бага, 19.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (4.3.). Өнгөрсөн онтой харьцуулахад нийтлэг байна гэж хариулсан нь 4.5 хувиар буурч, бага байна, мэдэхгүй гэсэн хариултууд тус бүр 3.7, 0.9 хувиар өсчээ. Татвараас зайлсхийх явдал нийтлэг байна гэсэн иргэдийн дүгнэлт бага зэрэг буурсан хэдий ч хувийн жингээрээ өндөр хэвээр байна.

#### 4.3. Татвараас зайлсхийх явдал таны бодлоор

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нийтлэг байна	2066	72.3%	3576	67.7%	-4.5%
Бага байна	264	9.2%	682	12.9%	3.7%
Мэдэхгүй	528	18.5%	1021	19.3%	0.9%

Нийт	2858	100.0%	5279	100.0%	0.0%
Хариулаагүй	19	0.7%	2	0.0%	-0.6%
Нийт	2877		5281		

Судалгаанд оролцсон иргэдийн 45.4 хувь нь бизнес эрхлэхэд шаардлагатай лиценц зөвшөөрлийн тоог багасгах, 24.7 хувь нь хэвийн, 29.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (4.4.). Иргэдийн тал орчим хувь нь бизнес эрхлэх зөвшөөрлийн тоог багасгах хэрэгтэй гэж үзэж байна. Өнгөрсөн оныхоос их байна гэсэн нь 2.9 хувиар буурсан бол хэвийн байна, мэдэхгүй гэсэн хариултууд тус тус 2.4, 0.5 хувиар өсчээ. Магадгүй энэ олон зөвшөөрөл, лиценз нь хүнд сурталын суурийг тавих, бизнесийн үйл ажиллагаанд саад болохын зэрэгцээ дарамтанд оруулах улмаар авилгал өгч авалцахын эхний алхам болж байгааг үгүйсгэхгүй.

#### 4.4. Бизнес эрхлэхэд шаардагдах зөвшөөрлийн тоо

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Их	1360	48.3%	2393	45.4%	-2.9%
Хэвийн	630	22.4%	1303	24.7%	2.4%
Мэдэхгүй	827	29.4%	1574	29.9%	0.5%
Нийт	2817	100.0%	5270	100.0%	0.0%
Хариулаагүй	60	2.1%	11	0.2%	-1.9%
Нийт	2877		5281		

#### 3.5. Банк санхүүгийн салбар

Монголбанкнаас явуулж буй мөнгөний бодлогын талаар иргэд ямар дүгнэлт хийж байгааг сонирхсон асуултанд хариулсан байдлыг авч үзвэл 43.8 хувь нь Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогод сэтгэл ханамжтай байдаг, 15.3 хувь нь сэтгэл ханамжгүй байдаг гэжээ. Харин энэ асуултанд мэдэхгүй гэж 40.9 хувь нь хариулжээ. Иргэдийн олонхи нь Монголбанкнаас явуулж буй бодлогыг дэмжиж байгаа нь үнийн дарамт арилж цаашид тогтворжсон, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом уналт зогсож зах зээлийн горимоор бага зэргийн хэлбэлзэлтэй болсон, банк санхүүгийн салбарын үйл ажиллагаа сэргэж иргэдэд найдвартай үйлчилж эхэлсэн, улсын гадаад валютын нөөц нэмэгдэн гадаад төлбөрийн чадвар сайжирсан зэрэгтэй холбоотой юм. Энэ бүхэн иргэн бүрийн хувийн амьдралд зохих хэмжээний хувь нэмэр оруулж байгаа учир дээрх хариултыг өгч байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Нөгөө талаас 40 гаруй хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь мөнгөний бодлогын үр дүнг бодит амьдрал дээр хүртэж байгаа хэдий ч энэ талаар ойлголт муутай байгаатай холбоотой болов уу. Ялангуяа энэ жил алслагдсан сумдаар явж судалгаа авсан учир дээрх дүгнэлт батлагдах магадлалтай юм. Иймд мөнгөний бодлого гэж юу байдаг, үр дүн нь ямар байгааг сурталчлах чиглэлээр Монголбанк дорвитой арга хэмжээг ялангуяа орон нутагт зохион байгуулах нь хэрэгтэй байна. Бас нэг зүйлийг тодруулахад мэдэхгүй гэсэн хариултыг эс оролцуулан тийм, үгүй хоёрын тоон болон хувьчилсан үзүүлэлтийг нь өнгөрсөн оныхтой харьцуулбал эерэг хариултын тоо нь өсч, эерэгийнх нь буурсан байна (5.1.).

#### 5.1. Монголбанкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлого таны санаанд нийцдэг үү?

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	1849	68.0%	2310	43.8%	-24%

Үгүй	827	30.4%	809	15.3%	-15%
Мэдэхгүй	45	1.7%	2155	40.9%	39%
Нийт	2721	100.0%	5274	100.0%	
Хариулаагүй	156	5.4%	7	0.1%	
Нийт	2877		5281		

2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол улсад 17 банк, 84 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 50.3 хувь нь үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоо боломжийн, 34.2 хувь нь олон байна, 8.0 хувь нь цөөн байна гэж хариулжээ (5.2.). Судалгаанд оролцсон иргэдийн тал гаруй хувь нь үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог боломжийн гэж үзсэн нь өнгөрсөн оныхоос 13.7 хувиар буурсан, цөөн байна гэсэн нь 0.6 хувиар багассан бол олон байна гэсэн нь 6.7 хувиар ихэссэн байна. Харин мэдэхгүй гэж 7.5 хувь нь хариулжээ.

### 5.2. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоо таны бодлоор

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Олон	784	27.5%	1803	34.2%	6.7%
Цөөн	244	8.5%	420	8.0%	-0.6%
Боломжийн	1828	64.0%	2657	50.3%	-13.7%
Мэдэхгүй	0	0.0%	398	7.5%	7.5%
Нийт	2856	100.0%	5278	100.0%	
Хариулаагүй	21	0.7%	3	0.1%	
Нийт	2877		5281		

Ихэнх иргэд маань одоо үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог боломжийн гэж үзэж байна. Энд зарим иргэд маань банк гэсэн ойлголтонд ББСБ-уудыг оруулж ойлгосныг үгүйсгэхгүй. Сүүлийн жилүүдэд олон арван ББСБ болон бусад санхүүгийн байгууллагууд бий болж банкны зарим үйл ажиллагааг бага түвшинд гүйцэтгэж өрсөлдөөнийг бий болгож байна. Иймд Монголбанкны зүгээс банкуудын хэмжээг томосгох, үйл ажиллагааг нь чанаржуулах үүднээс банкуудын дүрмийн санг 2004 онд 4 тэрбум болгохоор шийдвэрлэсэн билээ. Мэдээж тэр үед банкуудын хэмжээ томрон, тоо нь цөөрч, үйл ажиллагаа нь арай өндөр түвшинд явагдаж өрсөлдөх биз. Харин банкны зарим үйл ажиллагааг доод түвшинд банкуудтай зэрэгцэн бусад санхүүгийн байгууллагууд гүйцэтгэнэ. Мөн энд нэг зүйлийг нэмж хэлэхэд хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбаруудын тоо тогтмол өсч байхад ББСБ-ууд ховор хэвээр байна.

Манай улсын банк санхүүгийн салбарын үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд сайжирч байна гэж мэргэжилтнүүд болон олон улсын судлаачид дүгнэж байгаа. Харин иргэдийн зүгээс хэрхэн дүгнэж байгааг сонирхоё. Санал асуулгад оролцсон иргэдийн 40.8 хувь нь банк санхүүгийн салбарын үйл ажиллагааг найдвартай гэсэн нь өнгөрсөн оныхоос 13.3 хувиар өссөн, 42.4 хувь нь эргэлзээтэй гэсэн нь 22.8 хувиар буурсан, 7.8 хувь нь найдваргүй гэж хариулсан нь өнгөрсөн оны түвшинд байна. Харин 9.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (5.3.). Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ жилээс жилд арилж байгаа нь дээрх хариултаас харагдаж байна. Гэсэн хэдий ч тогтвортой гэсэн хариултаас эргэлзээтэй гэсэн хандлага давуу байгаа нь банкуудын тогтворжилт иргэдийн ой ухаанд бүрэн хүрээгүй, итгэлийг олох ажил бүрэн дуусаагүйг гэрчилнэ.

### 5.3. Банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Найдвартай	781	27.5%	2155	40.8%	13.3%
Эргэлзээтэй	1850	65.2%	2237	42.4%	-22.8%
Найдваргүй	207	7.3%	411	7.8%	0.5%
Мэдэхгүй	0	0.0%	477	9.0%	9.0%
Нийт	2838	100.0%	5280	100.0%	0.0%
Хариулаагүй	39	1.4%	1	0.0%	-1.3%
Нийт	2877		5281		


Банкинд итгэх итгэл нэмэгдсэн гэж 41.8 хувь үзэж байгаа бол 35.4 хувь нь хэвэндээ, 11.1 хувь нь буурсан, 11.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (5.4.). Өнгөрсөн оны санал асуулгад мэдэхгүй гэдэг хариултыг оруулаагүй учир нэмэгдсэн болон буурсан гэсэн хариултуудын хувийг тус тус 4.0, 8.9 нэгжээр бууруулсан болох талтай. Мэдэхгүй гэсэн хариултыг хасаад дахин хувьчилбал нэмэгдсэн гэсэн хариултынх 5.5 хувиар өсч, буурсных 7.4 хувиар багассан байна. Үүнийг мөн тоон үзүүлэлтүүдээс ч харж болно. Иргэдийн банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ багасч, итгэх итгэл нь нэмэгдэж байгааг дээрх хариултуудаас харагдаж байна.

#### 5.4. Банк санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл


	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдсэн	1309	45.8%	2206	41.8%	-4.0%
Буурсан	571	20.0%	588	11.1%	-8.9%
Хэвэндээ	976	34.2%	1868	35.4%	1.2%
Мэдэхгүй	0	0.0%	615	11.7%	11.7%
Нийт	2856	100.0%	5277	100.0%	
Хариулаагүй	21	0.7%	4	0.1%	-0.7%
Нийт	2877		5281		

Өнөөгийн байдлаар банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа нь өргөжиж, найдвартай болж байгаа нь иргэдийн итгэл ийнхүү дээшлэхэд нөлөөлсөн байх. Үүний нэг илрэл бол иргэд байгууллагуудын банк дахь хадгаламж, харилцахын хэмжээ өссөн явдал юм.

Зураг 9. Хадгаламж, тэрбум төгрөг



Зураг 10. Харилцах, тэрбум төгрөг



Зураг 9-өөс харахад төгрөгийн болон гадаад валютын хадгаламжийн хэмжээ 1991 оноос 1997 он хүртэл тогтмол өсч ирсэн ба банкны салбарын хямралын оргил үе болох 1998 онд буурч, 1999-2002 онуудад огцом өсөлттэй явж 282.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харилцах дансны өөрчлөлт хадгаламжтай адил түвшинд

явж харин 2001, 2002 онд огцом өссөн байна (Зураг 10.). Банкуудын найдвартай үйл ажиллагааг хангах үүднээс Монголбанк банкуудад тавих хяналт шалгалтаа чангатгаж, шалгалтыг эрсдэлийг дүгнэн удирдахад чиглүүлсэн ба банкуудын касс дахь бэлэн мөнгөний хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж, ингэснээр харилцагч нарын төлбөр, тооцоог түргэн шуурхай гүйцэтгэдэг болсон нь хүмүүсийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна.

Банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа олон нийтэд сайн сурталчилж эхэлж байгаа нь дараахь хариултаас харагдаж байна. Чадаж байна гэсэн хариулт өнгөрсөн оныхоос 18.5 нэгжээр нэмэгдэж 63.4 хувьд, чадахгүй байна 14.3 нэгжээр буурч 24.3 хувьд, мэдэхгүй 4.1 нэгжээр буурч 12.3 хувьд хүрчээ (5.5.).

#### 5.5. Банк санхүүгийн багууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Чадаж байна	1280	44.9%	3343	63.4%	18.5%
Чадахгүй байна	1099	38.6%	1279	24.3%	-14.3%
Мэдэхгүй	469	16.5%	651	12.3%	-4.1%
Нийт	2848	100.0%	5273	100.0%	0.0%
Хариулаагүй	29	1.0%	8	0.2%	-0.9%
Нийт	2877		5281		

Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ багассан, итгэх итгэл нь нэмэгдсэн энэ үед үйлчилгээ нь хэр зэрэг түргэн шуурхай явагдаж байгааг сонирхоё. Асуултанд хариулсан иргэдийн 56.9 хувь нь хувь хүнд хүрч түргэн шуурхай байна гэж хариулсан нь өнгөрсөн оныхоос 11.6 хувиар өсчээ. Харин 30.7 хувь нь хүнд сурталтай чирэгдэлтэй байна, 12.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь өнгөрсөн оныхоос тус тус 2.5, 9.2 хувиар буурсан байна (5.6.). Иймд банкууд өрсөлдөөнөө үйлчилгээгээ чанаржуулж эелдэг зөөлөн болгох, иргэдэд хүрч ажиллах чиглэлээр ажиллах орон зай байна хэмээн бид дүгнэж байна.

#### 5.6. Банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Хувь хүнд хүрч, хэвийн байна	1295	45.2%	3000	56.9%	11.6%
Хүнд сурталтай, чирэгдэлтэй	950	33.2%	1619	30.7%	-2.5%
Мэдэхгүй	617	21.6%	654	12.4%	-9.2%
Нийт	2862	100.0%	5273	100.0%	0.0%
Хариулаагүй	15	0.5%	8	0.2%	-0.4%
Нийт	2877		5281		

Танд мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандвал боломжтой вэ гэсэн сонирхолтой асуултанд 51.8 хувь нь банк, 21.6 хувь нь хувь хүн, 14.2 хувь нь ломбард, 7.0 хувь нь ББСБ, 5.5 хувь нь бусад эх үүсвэр гэж хариулжээ (5.7.). Хүнд мөнгөний хэрэгцээ гарвал хамгийн түрүүнд найз нөхөд, дотны хүмүүс болон ломбарданд ханддаг гэсэн өнгөрсөн оны хариултуудын хувь тус тус 16.9, 15.4

нэгжээр буурсан бол банк гэсэн хариултынх 33.4 нэгжээр өсч тэргүүлэх эгнээнд орсон байна.

#### 5.7. Танд мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ?

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Банк	553	18.3%	2734	51.8%	33.4%
ББСБ	175	5.8%	367	7.0%	1.1%
Ломбард	894	29.7%	751	14.2%	-15.4%
Хувь хүн	1160	38.5%	1138	21.6%	-16.9%
Бусад	232	7.7%	290	5.5%	-2.2%
Нийт	3014	100.0%	5280	100.0%	0.0%
Хариулаагүй	-137	-4.8%	1	0.0%	4.8%
Нийт	2877		5281		

Банкуудын үйл ажиллагаа сайжирч, үйлчилгээнийх нь төрөл ихэссэн, зөвхөн цөөн тооны найдвартай харилцагчдад их хэмжээний зээл олгохын зэрэгцээ цалин тэтгэврийн болон бусад төрлийн бичил зээлийг (үйлчилгээ) өргөн хүрээтэй олгож байгаа нь иргэдийн тэмүүллийг өөрсдийн зүг татаж байгаагийн илрэл юм. Хэдийгээр ББСБ-д хандах хувь өнгөрсөн оныхоос 1.1 хувиар өссөн ч хувийн жин нь их бага байна. Сайн үйл ажиллагаа явуулж буй цөөн тооны ББСБ-ууд байгаа хэдий ч тэдгээрийн тоо өсч үйлчилгээ нь олон нийтийг хамруулж чадахгүй байгааг анхаарах хэрэгтэй байна. Хувь хүнээс мөнгөний хэрэгцээгээ хангах явдал хүчтэй хэвээр байгаа нь санхүүгийн байгууллагууд санхүүгийн жуучлалаа өргөжүүлэх бололцоо байгааг дээрх тоо гэрчилж байна.

Өнөөгийн байдлаар Монгол улсад нийт 84 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) үйл ажиллагаа явуулж, хот, хөдөө орон нутгийн иргэдийг өөрсдийн харилцагчдаа болгон тэдэнд тодорхой хэмжээний үйлчилгээ үзүүлж байна. Судалгаанд оролцсон иргэд маань ББСБ-ын талаар хэр мэдлэгтэй байгааг сонирхоё. Асуултанд хариулсан нийт иргэдийн 37.4 хувь нь ББСБ-аар үйлчлүүлдэг, 56.9 хувь нь үйлчлүүлдэггүй, 5.7 хувь мэдэхгүй хариулжээ (5.8.). Өнгөрсөн онтой хаьцуулахад үйлчлүүлдэг болон үйлчлүүлдэггүй гэсэн хариултуудын тоо тус тус 3.4, 2.3 нэгжээр буурч, мэдэхгүй гэсэн хариултын тоо 5.7 хувиар нэмэгдсэн байна.

#### 5.8. Та банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг үү?

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	1155	40.8%	1973	37.4%	-3.4%
Үгүй	1674	59.2%	3001	56.9%	-2.3%
Мэдэхгүй	0	0.0%	301	5.7%	5.7%
Нийт	2829	100.0%	5275	100.0%	0.0%
Хариулаагүй	48	1.7%	6	0.1%	-1.6%
Нийт	2877		5281		

Үүнээс дүгнэхэд тоо нь олширч байгаа хэдий ч ББСБ-ууд маань цөөн тооны харилцагчдын хүрээнд үйлчилгээ явуулж байна. Мөн энд нэмж хэлэхэд сурталчилгаа сайн явуулж иргэдийг олноор татах шаардлагатай байна. ББСБ нь манай улсын хувьд шинээр бий болж буй санхүүгийн байгууллагын нэг хэлбэр юм. Удирдах байгууллагуудаас түүний хөгжлийг дэмжиж байгаа хэдий ч ажлын дадлага туршлага, боловсон хүчний мэдлэг ур чадвар дутмаг байгааг хэлэхэд илүүдэхгүй биз. Нөгөө талаас банк, ББСБ, бусад санхүүгийн байгууллагууд зах зээлийн зарчмын дагуу өрсөлдөөнийг бий болгож чадвал хүүний түвшин буурч

хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэн үйлчилгээ нь хувь хүн болгонд хүрнэ гэдгийг хэлмээр байна. Үүний зэрэгцээ тусгай чиглэлийн банк болон санхүүгийн байгууллагууд (хөрөнгө оруулалтын, хадгаламжийн, г.м.) үйл ажиллагаа явуулахыг мартаж болохгүй.

Өнөөдөр манай улсад гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалттай хэд хэдэн банк, ББСБ-ууд үйл ажиллагаа явуулж байна. Гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь манай улсад орж ирэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн улмаар үндэсний үйлдвэрлэлийг сэргээж дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөнд чухал үүрэг гүйцэтгэнэ. Түүний зэрэгцээ манай улсын банк санхүүгийн салбарт зах зээлийн өрсөлдөөнийг бий болгож банк санхүүгийн байгууллагуудыг чанаржуулахад тус дөхөм болно. Одоо манай иргэдийн зүгээс гадаадын банк болон санхүүгийн байгууллагуудыг Монголд оруулж ирэх нь ямар ач холбогдолтой вэ гэдгийг сонирхоё. 52.3 хувь нь ач холбогдолтой гэж хариулсан нь өнгөрсөн оныхоос 2.0 хувиар, 18.4 хувь нь ач холбогдолгүй гэсэн нь 4.9 хувиар тус тус өсч, мэдэхгүй гэсэн хариултын тоо 6.9 хувиар буурч 29.3 хувьд хүрчээ (5.9.).

#### 5.9. Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг оруулж ирэх нь

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Ач холбогдолтой	1435	50.3%	2758	52.3%	2.0%
Ач холбогдолгүй	384	13.5%	969	18.4%	4.9%
Мэдэхгүй	1033	36.2%	1546	29.3%	-6.9%
Нийт	2852	100.0%	5273	100.0%	0.0%
Хариулаагүй	25	0.9%	8	0.2%	-0.7%
Нийт	2877		5281		

Иргэдийн төлөөллийн тал гаруй хувь нь зөв буюу ашигтай гэж үзэж байгаа нь дээрх санаатай нэг байна гэсэн үг. Нэг зүйлийг нэмж хэлэхэд гадаадын банк санхүүгийн байгууллагуудыг оруулж ирэх нь манай улсын эдийн засгийн өсөлт хөгжилтөнд ашигтай харин улсынхаа эдийн засгийн багтаамж, зах зээлийн байдал, банк санхүүгийн салбарын хөгжил түүнд учруулж болзошгүй хохирлуудыг сайн тооцоолох нь зөв болов уу.

Өнгөрсөн оны судалгаагаар бэлэн бус тооцоо болон түүний дэвшилтэд хэрэгслүүдийн (картууд) талаар нилээд дэлгэрэнгүй санал асуулга явуулж нэгтгэн дүгнэсэн болно. Иргэдийн ихэнх хувь нь ойлголт байхгүй түүний давуу талыг мэдэхгүй байсан. Харин энэ жилийн хувьд маш товчхон буюу нэг л асуултыг хамрууллаа. Бэлэн бус тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг үү гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан иргэдийн 12.6 хувь тийм, 79.2 хувь нь үгүй, 8.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (5.10). Эндээс харахад иргэдийн ихэнх нь урьдын адил бэлэн бус тооцоо болон түүний хэрэгслүүдийн талаар ойлголт муутай, картыг хэрэглэдэггүй буюу хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Иймд банкуудад картын хэрэглэгчдийн тоогоо цаашид нэмэгдүүлэх зах зээлийн орон зай байна гэдэг нь мөн эндээс харагдлаа.

#### 5.10. Та бэлэн бус тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг үү?

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм			665	12.6%	12.6%
Үгүй			4181	79.2%	79.2%

Мэдэхгүй			430	8.2%	8.2%
Нийт			5276	100.0%	100.0%
Хариулаагүй			5	0.1%	0.1%
Нийт			5281		

### 3.6. Хадгаламж, хуримтлал

Өнгөрсөн оны судалгаагаар хэрвээ танд хэмнэх мөнгө гардаг бол та түүгээр юу хийх вэ (хийдэг вэ) гэсэн асуултанд судалгаанд оролцсон нийт иргэдийн 55.0 хувь нь хариулсан бөгөөд 27.5 хувь нь банкинд хадгалуулна, 25.2 хувь нь зээлдүүлнэ, 47.3 хувь нь бусад хэлбэрээр байлгана гэж харуулжээ. Энэ жилийн хувьд өнгөрсөн оны асуултуудыг багасгаж хариултуудын тоог дэлгэрүүлэн толилуулж байна. "Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ?" гэсэн асуултанд давхардсан тоогоор 21.9 хувь нь банкинд хадгалуулдаг, 9.4 хувь нь бусад зээлдүүлдэг, 30.7 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 1.4 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 1.5 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 35.0 хувь бусад гэсэн хариултыг өгчээ.

#### 6.1. Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Банкинд хадгалуулдаг	435	27.5%	1287	21.9%	-5.6%
Зээлдүүлдэг	399	25.2%	556	9.4%	-15.8%
Худалдаа наймаа хийдэг		0.0%	1806	30.7%	30.7%
Үнэт цаасанд байршуулдаг		0.0%	85	1.4%	1.4%
Хувьцаа худалдаж авдаг		0.0%	89	1.5%	1.5%
Бусад	749	47.3%	2062	35.0%	-12.3%
Нийт	1583	100.0%	5885	100.0%	0.0%
Хариулаагүй	1294	45.0%	-604	-11.4%	-56.4%
Нийт	2877		5281		

Зарим нэг хариултыг өнгөрсөн оныхтой харьцуулахад банкинд хадгалуулдаг гэснийх 5.6 хувиар буурсан хэдий ч тоон үзүүлэлтээрээ 3 дахин нэмэгдсэн, бусад зээлдүүлдэг гэснийх 15.8 хувиар буурсан, бусад гэснийх 12.3 хувиар буурчээ. Энэ хэсэгт дүгнэж хэлэхэд иргэдэд хэрвээ хуримтлуулсан мөнгө байдаг бол ихэнх тохиолдолд худалдаа наймаа хийх буюу банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг байна. Харин хувийн жингээрээ хамгийн их (35.0 хувь) буюу бусад гэсэн хариултанд хуримтлуулах мөнгөгүй иргэд хамрагдсан болов уу гэсэн таамаглалыг төрүүлж байна.

"Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулдаг вэ?" гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан иргэдийн 69.7 хувь нь бэлэн мөнгөний хэлбэрээр, 14.4 хувь нь бэлэн бус мөнгөний хэлбэрээр, 2.6 хувь нь үнэт цаасанд, 1.7 хувь нь хувьцаанд, 11.6 хувь нь бусад хэлбэрээр байршуулдаг байна (6.2.). Банк санхүүгийн байгууллагуудын тоо, үйлчилгээний төрөл олширч (хүн ам төвлөрсөн газруудад), бэлэн бус төлбөр тооцооны систем хөгжиж буй энэ үед иргэдийн 70.0 орчим хувь нь мөнгөө бэлнээр хадгалж байгаа нь нэгт, бэлэн бус төлбөр тооцооны систем буюу шаардлагатай үед бэлэн мөнгө авах нөхцөл нийт нутаг дэвсгэрийг хамарч чадаагүй, ялангуяа хөдөө орон нутагт сул хөгжөөгүй; хоёрт, санхүүгийн бусад хэрэгслүүдийн хөгжил сул дорой учир үнэт цаас, хувьцаа болон бусад хэрэгслүүдэд мөнгөө байршуулах боломжоор хязгаарлагдмал; гуравт, ямарваа

нэгэн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх мөнгөгүй зөвхөн амьжиргааныхаа хэдэн төгрөгтэй явдаг иргэд олон байгаатай холбоотой гэж үзэж байна.

### 6.2. Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг вэ

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Бэлэн мөнгөөр			3683	69.7%	69.7%
Бэлэн бус мөнгөний хэлбэрээр			759	14.4%	14.4%
Үнэт цаасаар			137	2.6%	2.6%
Хувьцаагаар			88	1.7%	1.7%
Бусад хэлбэрээр			614	11.6%	11.6%
Нийт			5281	100.0%	100.0%
Хариулаагүй			0	0.0%	0.0%
Нийт			5281		


Дээрх асуултуудтай уялдсан бас нэг сонирхолтой асуултанд юу гэж хариулсныг сонирхоё. Танд хэмнэх мөнгө гараад түүнийгээ банкинд юм уу эсвэл өөр ямар нэгэн газар байршуулах бол ямар валютыг илүүд үзэж байна вэ гэсэн асуултанд 87.9 хувь нь төгрөгөөр, 7.7 хувь нь америк доллараар, 1.1 хувь нь еврогоор, 3.3 хувь нь бусад валютаар гэж хариулжээ (6.3.). Өнгөрсөн онтой харьцуулахад төгрөгөөр гэсэн нь 28.1 хувиар өсч, америк долларынх 32.3 хувиар буурсан байна. Иргэд маань ийнхүү үндэснийхээ валютаар хуримтлалаа байршуулахыг илүүд үзэж байгаа нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшны уналт харьцангуй багассан, үнийн түвшин буурч тогтвортой болсон, төгрөгийн хадгаламжийн хүү өндөр байгаатай холбоотой болов уу. Мөн банк санхүүгийн байдал сүүлийн жилүүдэд илт сэргэсэн, Монгол улсын хүн ам төвлөрсөн нутаг дэвсгэрт төгрөгийн бэлэн бус төлбөр тооцооны шинэ хэрэгслүүд эрчимтэй хөгжиж байгааг дурьдахад илүүдэхгүй биз. Түүний зэрэгцээ хөдөө орон нутагт зөвхөн төгрөгийн үйлчилгээ явагдаж байгааг хэлэхэд илүүдэхгүй биз.

### 6.3. Та мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Төгрөгөөр	1657	59.8%	4639	87.9%	28.1%
Америк доллараар	1109	40.0%	406	7.7%	-32.3%
Еврогоор		0.0%	57	1.1%	1.1%
Бусад	6	0.2%	175	3.3%	3.1%
Нийт	2772	100.0%	5277	100.0%	0.0%
Хариулаагүй	105	3.6%	4	0.1%	-3.6%
Нийт	2877		5281		

Зураг 11. Төгрөгийн болон валютын хадгаламж,  
тэрбум төгрөг

Зураг 12. Хадгаламжийн нэрлэсэн хүү ба инфляци, жилээр



Зураг 11-аас харахад 1991-1996 онуудад төгрөгийн хадгаламжийн хэмжээ давамгайлж байсан (1993 оныг оруулалгүйгээр) бол 1997-2001 он хүртэл валютын хадгаламж зохилсон байна (1998 оныг оруулалгүйгээр). Харин 2002 онд эргээд төгрөгийн хадгаламжийн хэмжээ валютынхаас илүү гарчээ.

Өрхөд нь хэмнэх мөнгө гардаг болон гарах тохиолдолд иргэдийн 21.9 хувь нь банкинд мөнгөө хадгалуулдаг гэж хариулсныг санаж байгаа байх. Одоо харин тэдгээр иргэдээс болон бусад санал асуулгад оролцсон хүмүүсээс өнөөгийн хадгаламжийн хүү ямар түвшинд байгааг асууя. Асуултанд хариулсан иргэдийн 31.0 хувь нь одоогийн хадгаламжийн хүүний түвшин боломжийн байна, 55.4 хувь нь бага байна, 13.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (6.4.). Өнгөрсөн онтой харьцуулахад бага байна гэсэн хариултынх 27.0 хувиар нэмэгдсэн байхад боломжийн байн, мэдэхгүй гэснийх тус тус 16.6, 10.4 хувиар буурсан байна. Иргэд маань аль болох өндөр хүүтэйгээр хадгаламжаа байршуулахыг хүсэх нь мэдээж. Харин эдийн засгийн болон зах зээлийн байдлыг сайн судалж аль болох найдвартай, ашигтай зүйлд хөрөнгөө байршуулах нь зөв юм. Магадгүй энэ тал дээр мэдээлэл хомс, үйл ажиллагаа хязгаарлагдмал байгааг удирдах газрууд анхааралдаа авах хэрэгтэй байна. Мөн инфляцийн түвшин сүүлийн жилүүдэд тогтмол буурч нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх болсон нь хадгаламжийн хүүний түвшинг багасгахад нөлөөлсөн байж болох талтай. Хэдий тийм ч 1997 оны 9-р сараас эхлэн хадгаламжийн бодит хүүний түвшин эерэг түвшинд байгааг анхааралдаа авна уу (Зураг 12).

#### 6.4. Хадгаламжийн хүү таны бодлоор

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Бага байна	797	28.3%	2904	55.4%	27.0%
Боломжийн байна	1341	47.7%	1628	31.0%	-16.6%
Мэдэхгүй	676	24.0%	713	13.6%	-10.4%
Нийт	2814	100.0%	5245	100.0%	0.0%
Хариулаагүй	63	2.2%	36	0.7%	-1.5%
Нийт	2877		5281		

#### 3.7. Зээл

Хүн бүрт зээлийн эрэлт хэрэгцээ ямар нэгэн хэмжээгээр байдаг л байх. Гагцхүү тэр эрэлт хэрэгцээний эх үүсвэрийг (нийлүүлэлт) яаж олох, мөн тухайн эх үүсвэрийн өртөг (хүү) ямар түвшинд байгааг сайн тооцоолох хэрэгтэй болов уу. Өнөөгийн байдлаар инфляцийн түвшин багасч тогтворжин, түүнийг даган хадгаламжийн хүү буурч байгаа хэдий ч зээлийн хүү дорвитой буурахгүй байгаа

нь зээлийн эрсдэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг хаан боогдуулах улмаар эдийн засгийн өсөлтөнд сөрөг үзүүлж болзошгүй юм.

#### 7.1. Танд зээлийн хэрэгцээ байдаг уу

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	2304	80.8%	4249	80.5%	-0.3%
Үгүй	549	19.2%	839	15.9%	-3.4%
Мэдэхгүй	0	0.0%	192	3.6%	3.6%
Нийт	2853	100.0%	5280	100.0%	
Хариулаагүй	24	0.8%	1	0.02%	
Нийт	2877		5281		

Зээлийн хэрэгцээ танд байдаг уу гэсэн асуултанд 80.5 хувь нь тийм, 15.9 хувь нь үгүй гэж хариулсан байна (7.1.). Харин 3.6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Зээлийн хэрэгцээ байдаггүй гэж хариулсан хүмүүсийн хувь өнгөрсөн оныхоос 3.4 нэгжээр буурч, мэдэхгүй гэсэн хариулт уруу шилжсэнийг эс тооцвол зээлийн эрэлт урьдын адил өндөр хэвээр байна. Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнхид (80.5 хувь) зээлийн хэрэгцээ байдаг бөгөөд харин хүртээмж нь зөвхөн 33.2 хувьд нь л ногддог байна. 46.6 хувьд нь зээлийн хүртээмж байдаггүй, 20.1 хувь нь зээлийн талаар ойлголт муутай гэж хариулжээ (7.2.).

#### 7.2. Танд банк санхүүгийн байгууллагаас олгож буй зээл хүртээмжтэй байдаг уу

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм			1753	33.2%	33.2%
Үгүй			2461	46.6%	46.6%
Мэдэхгүй			1063	20.1%	20.1%
Нийт			5277	100.0%	
Хариулаагүй			4	0.1%	
Нийт			5281		


Зээлийн эрэлт өндөр, хүртээмж буюу нийлүүлэлт бага байгаа энэ үед банк санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж судалгаанд оролцсон иргэдийн 32.4 хувь, хүндрэлтэй гэж 51.8 хувь, мэдэхгүй гэж 15.7 хувь нь үзжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад хүндрэлгүй гэсэн хариултын хувь 12.7 хувиар нэмэгдэж, хүндрэлтэй болон мэдэхгүй гэсэн хариултынх тус тус 8.1, 4.6 хувиар буурчээ (7.3). Эндээс харахад зээл авдаг (хүртээмжэй) иргэдийн хувьд хүндрэл байдаггүй бөгөөд авч үзээгүй, авдаггүй эсвэл ойлголт байхгүй (зээлийн эрэлт хэдий байгаа ч) иргэдийн хувьд хүндрэлтэй байдаг байна.

#### 7.3. Таны бодлоор банк санхүүгийн байгууллагаас зээл авахад

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Хүндрэлгүй	563	19.8%	1710	32.4%	12.7%
Хүндрэлтэй	1706	59.9%	2731	51.8%	-8.1%
Мэдэхгүй	578	20.3%	830	15.7%	-4.6%
Нийт	2847	100.0%	5271	100.0%	
Хариулаагүй	30	1.0%	10	0.2%	
Нийт	2877		5281		

Зураг 13. Зээл, тэрбум төгрөг

Зураг 14. Зээлийн хүү ба инфляци, жилээр



Инфляцын түвшин буурч түүнийг даган хадгаламжийн хүү багасаж байхад зээлийн хүү дорвитой буурч өгөхгүй байгаа хандлага бий (Зураг 14). Харин одоо санал асуулгад оролцсон иргэд маань зээлийн хүүний талаар юу гэж бодож байгааг сонирхоё. 60.2 хувь нь зээлийн хүүг өндөр байна гэж хариулсан нь өнгөрсөн оныхоос 5.3 хувиар нэмэгдсэн, 29.0 хувь нь боломжийн гэсэн нь 16.0 хувиар буурчээ. Харин 10.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (7.4.). Энд нэг зүйлийг онцлон хэлэхэд банкууд зээл олгохдоо зээлийн эх үүсвэр, зориулалт, хугацаа болон харилцагчдын байдлыг харгалзан хүүг сарын нэгээс тав хүртэлх хувиар тогтоож байна. Судалгаанд оролцсон иргэдийн хэд нь банкнаас зээл авдаг, авдаггүйг сайн мэдэхгүй. Магадгүй зарим нь өндөр хүүгээр, зарим нь бага хүүгээр авдаг байх. Хэдий тийм ч 60 гаруй хувь нь одоогийн зээлийн хүүг өндөр гэж үзэж байгаа нь зээлийн хүүг салбарын хэмжээгээр буулгах дохио болж буйг харуулж байна.

#### 7.4. Таны бодлоор зээлийн хүү

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Өндөр	1459	54.9%	3175	60.2%	5.3%
Боломжийн	1195	45.0%	1529	29.0%	-16.0%
Мэдэхгүй	3	0.1%	568	10.8%	10.7%
Нийт	2657	100.0%	5272	100.0%	
Хариулаагүй	220	7.6%	9	0.2%	
Нийт	2877		5281		

Зээлийн хүүг салбарын хэмжээгээр бууруулах тал дээр Монголбанкны удирдлагын зүгээс нилээд арга хэмжээ авч хэрэгжүүлээд байна. Үүнд: банкуудын удирдлагуудтай хэд хэдэн удаа уулзалт зохион байгуулж зээлийг хүүг яаж багасгах тал дээр санал солилцсон, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран төслийн хүрээнд ажлын байр шинээр бий болгох болон орон сууцны зориулалттай урт болон дунд хугацааны бага хүүтэй зээлийг банкуудаар дамжуулан олгох ажлыг зохион байгуулж байгаа, санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнийг (ялангуяа зээлийн талаар) бий болгохын тулд ББСБ-ын үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлахгүй олгож байгаа зэрэг болно.

#### 3.9. Бусад асуудлууд

Монгол улсын төсвийн бодлогод реформ (татварын тогтолцоо болон бодлогыг сайжруулах, зардлын бүтцээ өөрчлөх г.м.) хийхгүй бол сүүлийн жилүүдэд шүүмжлэлд өртөн улмаар эдийн засгийнхаа байдлыг хүндрүүлэх магадлалтай байна. Энэ нь ч санал асуулгад оролцсон иргэдийн хариултаас

харагдаж байна. 14.5 хувь нь төсвийн бодлогын хэрэгжилт сайн байна гэж үзсэн байхад 24.9 хувь нь муу, 31.1 хувь хэвэндээ, 29.5 хувь мэдэхгүй гэж хариулжээ.

#### 8.1. Монгол улсын төсвийн бодлогын хэрэгжилт таны бодлоор

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Сайн байна			765	14.5%	14.5%
Муу байна			1312	24.9%	24.9%
Хэвэндээ байна			1638	31.1%	31.1%
Мэдэхгүй			1557	29.5%	29.5%
Нийт			5272	100.0%	100.0%
Хариулаагүй			4	0.1%	0.1%
Нийт			5281		

Татварын ерөнхий түвшин жилээс жилд өсч, ачаалал нь иргэдэд хүндээр тусч байгаа энэ үед төсвийн бодлогыг сайн байна гэж хариулахгүй мэдээж. Дээр татварын дарамт (ачаалал) ДНБ-ий 29 хувь болтлоо өссөн гэж дурьдсаныг та бүхэн санаж байгаа байх. Үүнийг шилжилтийн болон хөгжиж буй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Тэдгээр улсуудын хувьд дунджаар 10-20 хувь болон түүнээс доогуур байдаг байна.

Гаалийн байгууллагын хувьд ч төсвийн бодлогын хэрэгжилтийн нэгэн адил иргэдийн зүгээс тааруухан хариултыг өгчээ. 10.5 хувь нь үйл ажиллагаа нь сайн гэж дүгнэсэн бол 36.3 хувь нь муу, 24.1 хувь хэвэндээ, 29.0 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Гаалийн байгууллагын үйл ажиллагааг ямар тохиолдолд сайн ямар тохиолдолд муу гэж дүгнэн хэлэхэд мэргэжлийн биш хүний хувьд хэцүү асуудал байх. Улсын төсөвт гаалийн татварын орлогыг сайн бүрдүүлдэг (төлөвлөгөөгөө биелүүлэх), хил хязгаарын гадаад худалдааны онцгой зөрчил дутагдлыг цаг тухайд нь илрүүлдэг, хээл хахуульд автдаггүй ийм л байвал сайн гэж дүгнэх болов уу. Харин иргэд маань ингэж бодохгүй байгаа нь харамсалтай байна.

#### 8.2. Монгол улсын гаалийн байгууллагын үйл ажиллагаа

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Сайн байна			554	10.5%	10.5%
Муу байна			1915	36.3%	36.3%
Хэвэндээ байна			1272	24.1%	24.1%
Мэдэхгүй			1529	29.0%	29.0%
Нийт			5270	100.0%	100.0%
Хариулаагүй			4	0.1%	0.1%
Нийт			5281		

Орчин үеийн техникжсэн фермерүүдийн суурийг бүрдүүлж чадвал манай улсын ХАА-н салбар сэргэн хөгжих болно гэж судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх буюу 64.4 үзэж байна. Харин 20.1 хувь нь эргээд нэгдэл, сангийн аж ахуйн хэлбэрт шилжих нь зөв гэж хариулжээ. 6.6 хувь нь хэвэнд нь байлгах, 8.9

хувь нь бусад арга замаар ХАА-н салбарыг сэргээх шаардлага байна гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Энэ асуудал дээр туршлага судалсан мэргэжлийн хүмүүс ихийг зөвлөж, бүтээнэ гэдэгт найдаж байна. Түүний зэрэгцээ энэ салбарт ажиллаж, амьдарч байгаа иргэд маань ч нэгийг хэлэх нь гарцаагүй.

### 8.3. Хөдөө аж ахуйн салбарыг яаж сэргээх вэ

	2002		2003		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Техникжсэн фермер болгох			3390	64.4%	64.4%
Нэгдэл, САА-н хэлбэрт			1056	20.1%	20.1%
Хэвэнд нь байлгах			348	6.6%	6.6%
Бусад			471	8.9%	8.9%
Нийт			5265	100.0%	100.0%
Хариулаагүй			4	0.1%	0.1%
Нийт			5281		

## 4. Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлын (санал асуулга) хүрээнд зах зээлийн системд шилжин орсноос хойш өнөөг хүртэл (2002 он) Монгол улсын эдийн засгийн байдал, нийгмийн хурцадсан асуудлууд, гадаадаас орж буй хөрөнгийн урсгал, татварын тогтолцоо болон ачаалал, хөрөнгийн биржийн үйл ажиллагаа, банк санхүүгийн салбарын хөгжил үүнээс хадгаламж, зээл, бэлэн бус төлбөр тооцоо, мөнгөн дэвсгэртүүд болон зоосон мөнгөний хэрэглээний талаар төв суурин газар болон хөдөө орон нутгийн иргэд маань ямар санал бодолтой байгааг нэгтгэн дүгнэж бодит байдалтай (тоон үзүүлэлтүүдтэй) харьцуулан дүн шинжилгээ хийлээ. Түүний зэрэгцээ өнгөрсөн оны (2002) судалгаа дээр тулгуурлан иргэдийн санал бодол хэр өөрчлөгдсөнийг харьцуулан дүгнэсэн болно. Тайлант оны судалгааны ажлын бас нэг онцлог бол санал асуулгад оролцсон иргэдийг орон нутгийн харьяалал, хүйс, нас, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал, намын гишүүнчлэлээр нь бүлэглэн хувааж тус бүрээр нь тайлбар хийсэнд оршино (Хавсралт I-VI). Судалгааны ажил нь нийгэм, эдийн засгийн олон чухал асуудлуудыг агуулсан учраас дэлгэрэнгүй тайлбар хийхэд их цаг хугацаа өөр бусад олон зүйл шаардагдах тул аль болох товчхон оновчтой тайлбар хийсэн болно. Дараа дараагийн судалгааны ажлыг хийхдээ тухайн цаг үеийн нийгэм, эдийн засгийн дэвшилтэт болон тулгамдсан асуудлуудыг тус бүрээр болон тусад нь авч үзвэл илүү дэлгэрэнгүй, илүү оновчтой болно гэдгийг нэмж хэлмээр байна. Судалгааны ажлын асуулт бүрээр тодорхой хэмжээний тайлбар дүгнэлтүүдийг хийсний зэрэгцээ хавралт болгонд зохих хэмжээний дүгнэлтүүдийг тусгасан учир энэхүү төгсгөлийн хэсэгт дээр ангилсан дэд бүлэг тус бүрээр товчхон дүгнэж цаашид авах арга хэмжээний талаар дурьдсан болно.

Зах зээлийн системд шилжсэн 1990 оноос хойш 1993 он хүртэл шинэ нийгмийн үндэс суурийг тавих, бүтцийг байгуулах, тэдгээрт хэвшихэд их хүндрэл бэрхшээлүүд учирч байсныг хүн бүхэн санаж байгаа байх. Эдийн засгийн өсөлт (ДНБ) бараг бүх салбарт сөрөг гарч ерөнхийдөө уналтын байдалд орж байв. Эд барааны хомсдол, үнийн огцом өсөлт, төгрөгийн ханшийн уналт, үндэсний үйлдвэрлэлийн зогсонги байдал, ажилгүйдэл, ядуурал, гадаад худалдааны бууралт зэрэг олон хүндрэл бэрхшээлүүдийг дурьдаж болно. Энэ бүхнийг амжилттай даван туулсны дараа буюу 1994-1999 онуудад эдийн засгийн байдал сэргэж өсөлт нь хэдий тийм өндөр биш (2.3-6.3 хувийн хооронд) боловч чамлахааргүй түвшинд хүрч байжээ. 2000, 2001 онуудад эдийн засгийн өсөлт өндөр гарах магадлал байсан хэдий ч байгалийн гамшигаас шалтгаалан ДНБ-д өндөр хувийн жин эзэлдэг ХАА-н салбарийн үйлдвэрлэл 14.4-16.0 хувь хүртэл

уналтанд орж эдийн засгийн өсөлт 1.1 хувьтай гарсан байна. Харин 2002 онд ХАА-н салбарын уналтын эрч саарсан, тэвэр холбоо, худалдаа үйлчилгээний салбаруудын өсөлт нэмэгдсэнээс үүдэн эдийн засгийн өсөлт 3.9 хувьд хүрчээ (2003 оны 11 сарын 21-ний өдөр СЭЗЯ ДНБ-ий өсөлтийг 5.3 хувьд хүрсэн гэж албан бусаар мэдээлсэн). Үүнээс үзэхэд манай улсын эдийн засгийн байдал цаашид улам сайжрах хандлагатай байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Санал асуулгад оролцсон иргэдийн хариултаас харахад манай улсын эдийн засгийн өнөөгийн байдал ерөнхийдөө сайжирч байна (өнгөрсөн оныхоос 4.1 хувиар нэмэгдэж, хувийн жингээрээ тэргүүлэх болсон) гэсэн нь дээрх дүгнэлтийг мөн бататгаж байна. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2002 онд (1995 оныг оруулалгүйгээр) өмнөх онуудынхаас илт өссөн (442.2 америк доллар) хэдий ч харьцангуй доогуур байгаа нь сэтгэлийг зовоосон асуудал хэвээр байна. Хүн амын өсөлт тодорхой хэмжээгээр жилээс жилд явагдах учир түүний өсөлтөөс эдийн засгийн өсөлтийн хурдацтай энэ үзүүлэлт өсөх нь тодорхой. Иймд эдийн засгийн өсөлтөө аль болох хурдасгах мөн түүнийгээ тогтвортой байлгах зорилт бидний өмнө тавигдаж байна. Санал асуулгад оролцсон иргэдийн бодлоор татварын дарамтыг багасгаж, зээлийн хүүг бууруулан хөрөнгө оруулалтыг урамшуулахын зэрэгцээ үндэсний үйлдвэрлэл, бизнесменүүдээ хөхүүлэн дэмжвэл эдийн засгийг хурдацтай хөгжүүлж болно гэж үзжээ. Ялангуяа энэ жил судалгаанд оролцсон иргэд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэсэн шинэ хариултауд дээр их ач холбогдол өгчээ. Өнгөрсөн онд уул уурхай, олборлох үйлдвэрлэл, ХАА, боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудыг эдийн засгийн өсөлтөнд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж хариулж байсан бол энэ онд мөн л ХАА, уул уурхай, олборлох үйлдвэрлэл дурьдахын зэрэгцээ аялал жуулчлалын салбарт ач холбогдол өгсөн байна. Сүүлийн жилүүдэд дээр дурьдсан салбаруудаас ХАА-н салбарын байдал хүндрэлд орж өсөлт нь их хэмжээгээр буурчээ. Цаашид эдийн засгийн өсөлтийг түргэсгэхийн тулд бусад салбаруудад гарч буй амжилтыг дэмжихийн зэрэгцээ ХАА-н салбарт дорвитой өөрчлөлт хийх шаардлагатай байна гэсэн өнгөрсөн оны дүгнэлтийг дахин давтахад хүргэлээ.

Судалгаанд оролцсон иргэд өнөөгийн эдийн засгийн байдал сайжирч байна гэж дүгнэсэн мөртлөө өрхийн амьжиргааны түвшин доошилсон, хүн амын ядуурал нэмэгдсэн, ажилгүйчүүдийн тоо ихсэж байгаа гэж хариулсан нь эдийн засагт бүрдэж буй нийгмийн баялаг хувь хүн болон өрхөд хүртэхгүй байгаа, тухайн хүний бодит амьдрал дээр ядуурал, ажилгүйдэл гэх мэт нийгмийн эмзэг асуудлууд ажиглагдаж байгаатай холбоотой байж болох юм. Эдийн засаг нь сайжирч (ДНБ-ий өсөлт урьд онуудаас өсч 3.9 хувь болсон, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ харьцангуй өссөн) байгаа үед иргэдийн амьдрал дагаад бага ч гэсэн дээшлэх ёстой болов уу. Харин энэ удаа буюу энэ оны судалгаагаар эсрэг гарсан нь судлаачид бидний сонирхлыг ихэд татаж байна. Үүнд тайлбар хийхэд багагүй цаг хугацаа, хүндрэл бэрхшээлүүд учрах бөгөөд юуны түрүүнд тоон мэдээллүүдийг дахин нэг харж тунгаан бодъёо. ҮСГ-аас гаргадаг статистикийн тоон үзүүлэлтээс харахад ажилгүйчүүдийн тоо болон түвшин сүүлийн жилүүдэд тогтмол буурч байна. Ажиллах хүчнээ гадаадад тогтмол тодорхой хэмжээгээр гаргаж байгаа мөн дотооддоо олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр ажлын байр нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлж байгаа нь ажилгүйчүүдийн тоог багасгах үндэс болж байна. Энд нэг зүйлийг тодруулж хэлэхэд жижиг худалдаа наймаа хийж өөрсдийгөө авч явж байгаа иргэдийг ямар ангилалд оруулж байгаа, тэдний орлогыг хэрхэн тодорхойлж байгаа нь тодорхой бус байна. Түүний зэрэгцээ өөрсдөө идэвхтэй ажил хөдөлмөр хайж хөөцөлдөхгүй, ажиллах сонирхол хүсэлгүй хүмүүс байгааг үгүйсгэхгүй. Төр засгаас эдгээр хүмүүст анхаарал тавин хөдөлмөр эрхлүүлэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

Ялангуяа хувиараа хөдөлмөр эрхлэх орчныг нь бүрдүүлж өгөх, түүнийгээ сурталчлан нийгмийг хамруулах нь өнөөгийн чухал асуудал хэвээр байна. Манай улсын эдийн засгийн өсөлт тийм өндөр биш түүнийг даган нэг хүнд ногдох орлогын түвшин доогуур байгаа нь ядуу орнуудын тоонд зүй ёсоор орж байна. Мөн нийгмийн орлогын хуваарилалтын тэгш бус байдал, ядуучуудын түвшин (өдрийн нэг ам. доллараас доош орлоготой) өндөр байгаа нь үүний нэг нотолгоо юм. Энэ талаар ч санал асуулгад оролцсон иргэдийн ихэнх нь санал нэгтэй байсан. Ядуурлаас ангижрах нь тийм ч амар хурдан шийдвэрлэх асуудал биш гэдэг нь бусад улс орнуудын түүхэн замнал харуулж байна. Харин түүнийг яаж газар авахуулахгүйгээр зогсоох, цаашид багасгах арга хэмжээг цаг алдалгүй авах нь чухал юм. Манай улсын хувьд ОУВС-гаас ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж байгаа мөн дээр дурьдсанчлан иргэдэд хувиараа хөдөлмөр эрхлэх орчин болон боломжийг бүрдүүлж өгвөл зөвхөн ядуурал буурахаас гадна ажилгүйчүүдийн эгнээнд байгаа хүмүүсийн тоо ч цөөрнө. Үүнийг дагаад өрхийн орлого ч нэмэгдэх болно шүү дээ. Иргэд маань өөрийн тодорхой хэмжээний газартай болох нь өрхөд нь болон амьдралд нь их ашиг тус үзүүлнэ. Үүнийг ч тэд сайн ойлгож эхэлсэн нь газар өнгөрсөн онтой харьцуулахад газар хувьчлалыг ихэнх нь дэмжсэнд оршино. Харин газар хувьчлалын үйл ажиллагаа хэрхэн явагдаж байн вэ гэсэн асуултанд иргэдийн санал бодол ерөнхийдөө тэнцүү эсрэг тэсрэг хуваагдсан байна. Энэ үйл ажиллагааг хууль зүйн хүрээнд шударга зөв явуулж чадвал нийгмийн бусад эмзэг асуудлуудыг бага боловч хэсгийг нь шийдвэрлэж болно гэдэгт эргэлзэхгүй байна. Эцэст хэлэхэд, манай улсад үйлчилж буй даатгалын тогтолцоо иргэд, байгууллагыг бүрэн хамруулж чадахгүйгээс гадна үйл ажиллагаа нь тогтмол жигд явагдахгүй байна. Иймээс даатгалын тогтолцоог бүхэлд нь шинэчлэн, иргэд, байгууллагыг аль болох бүрэн хохиролгүй хамруулж, нийгэмд хэвшил болгох хэрэгтэй байна. Даатгал гэж юу байдаг, яаж даатгуулах, даатгалаа хэрхэн ашиглаж үр өгөөжийг нь яаж хүртэх тал дээр тодорхой ажлуудыг зохион байгуулах нь нэн шаардлагатай байна.

Гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж зэрэг гаднаас орж буй хөрөнгийн урсгалыг зөв зохистой хуваарилаж эдийн засгийн бүтээмжийг дээшлүүлэх нь манай улсын нийгэм болон эдийн засгийн хөгжилд их тус болно. Гадаадаас авч буй зээл тусламжийн ашиглалт хангалтгүй байна гэж (өнгөрсөн оныхоос харьцангуй буурсан хэдий ч) иргэдийн ихэнх нь үзсэн нь үр дүнгээ өгч чадахгүй эсвэл нийтийн хүртээл болж хувь хүнд хүрч чадахгүй, болж байгаа ч түүнийгээ сурталчилж харуулахгүй байгаатай холбоотой болов уу. Гадаадын зээл тусламж нэмэгдэж байгаагийн зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ жилээс жилд өсч байна. Иргэдийн санаа бодлоор гадаадаас зээл авахын оронд хөрөнгө оруулалтынх нь орчинг сайн бүрдүүлж өгвөл манай улсын хувьд илүү үр өгөөжтэй гэж хариулсан хэвээр байна. Гадаадын хөрөнгө оруулалт нь манай улсын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг шинээр бий болгох, улмаар эдийн засгийн өсөлтийг дээшлүүлэхэд их үүрэг гүйцэтгэнэ. Манай улсын хувьд хөрөнгө оруулалтын орчныг сайн бүрдүүлж өгөхийн зэрэгцээ аль салбарт ямар хэмжээгээр оруулахыг стратегийн хувьд сайн тооцоолох нь зөв юм. Энэ оны санал асуулгад шинээр тавигдсан асуултуудын нэг болох гадаадын байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслүүд таны хувьд гэсэн асуултанд иргэдийн ихэнх нь хүртээмжгүй болон мэдэхгүй гэж хариулжээ. Шинэ тогтолцоонд шилжсэнээс хойш манай улсад гадаад орнуудын болон олон улсын санхүүгийн байгууллагуудын олон зуун төслүүд амжилттай хэрэгжиж, одоо ч үргэлжилсээр байна. Чухам үр дүн нь иргэдэд яагаад нэг их хүртээмжгүй байна вэ? Үр дүн нь үнэхээр тэдэнд хүртээмжгүй байна уу, үр дүн нь шууд биш ч гэсэн тэдэнд ямар нэгэн сувгаар очиж байгааг ойлгохгүй байна уу гэсэн олон асуудлууд дээр цаашид анхаарах хэрэгтэй байна.

Татварын ачаалал 1991 оноос хойш тогтмол нэмэгдсээр 2002 оны байдлаар ДНБ-ий 29 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оныхоос татварын ачаалал их болон татвараас зайлсхийх явдал түгээмэл байна гэсэн хариултуудын хувь бага зэрэг буурсан ч иргэдийн дийлэнх (66.0-73.3 хувь нь) татварын ерөнхий түвшин өндөр, ачаалал нь сүүлийн жилүүдэд улам нэмэгдэж байгаа, татвараас зайлсхийх явдал нийтлэг болсон гэж үзсэн хэвээр байна. Мөн татварын дарамт эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлж байна (25.1 хувь) гэж хариулсныг санаж байгаа байх. Иймээс татварын дарамтыг багасгаж, уян хатан бодлого болон тогтолцоог бий болгох тал дээр арга хэмжээ авах цаг нь болжээ гэсэн өнгөрсөн оны дүгнэлтийг дахин давтаж хэлмээр байна. Тухайлбал, хувь хүн, аж ажуйн нэгж, байгууллага бүрт ногдох татварын хэмжээг ерөнхийд нь бууруулан татварт хамрагдахгүй байгаа, татвараас зайлсхийж буй хуулийн этгээдүүдийг бүрэн хамруулж төсвийн орлогыг бүрдүүлэх хэрэгтэй байна. Ингэхийн тулд өргөн хүрээтэй олныг хамруулсан шуурхай ажлыг тогтмол зохион явуулах, зар сурталчилгааны үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлэх, тогтмол татвар төлөгчдөд зохих хэмжээний урамшуулал хөнгөлөлт үзүүлж түүнийгээ сурталчлах (зөвхөн нэг удаагийн баярын бичиг, мөнгөн хөрөнгөөр шагнаад зогсохгүй), татвараас зайлсхийгчдэд хуулийн хатуу хариуцлага тооцох, түүний хууль зүйн орчинг боловсронгуй болгох, бусад орнуудын туршлагыг судалж өндөр мэдлэгтэй боловсон хүчин бэлдэх зэрэг олон ажлыг цаг алдалгүй хийх шаардлагатай байна. Үүний зэрэгцээ бизнес эрхлэхэд шаардлагатай лиценз зөвшөөрлийн тоог багасгах шаардлагатай байгаа нь өнгөрсөн оны адил иргэдийн хариултаас харагдаж байна. Лиценз зөвшөөрлийн тоо их байгаа нь ажил хэрэгч хүмүүст дарамт учруулж, хүнд суртал улмаар авилгалын эх үүсвэрийг бүрдүүлж өгөх нь хэн бүхэнд тодорхой билээ.

Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх нь өнгөрсөн оны нэгэн адил Монголбанкнаас явуулж буй бодлогуудыг дэмжиж байгаа нь инфляцийн түвшин буурч нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх болсон, төгрөгийн ханшийн уналт суларч улсын гадаад валютын нөөц нэмэгдсэн, банк санхүүгийн салбар эрүүлжиж санхүүгийн зуучлал гүнзгийрсэн, зээлийн хэмжээ ихсэж эдийн засаг дахь хөрөнгө оруулалт нэмэгдсэн, хадгаламжийн хэмжээ өсч банкинд итгэх итгэл дээшилсэн, хүүний түвшин харьцангуй буурсан, төлбөр тооцоо түргэн шуурхай болохын зэрэгцээ төлбөрийн шинэ дэвшилтэт хэлбэр болох картын үйлчилгээ нэвтэрсэн зэрэгтэй холбоотой юм. Тэдний бодлоор өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй банкуудын (ББСБ-ын тоог оруулж тооцсоныг үгүйсгэхгүй) тоог өнгөрсөн оны хариулттай харьцуулахад олон байна гэж үзсэн хэдий ч ихэнх нь боломжийн гэж дүгнэсэн байна. Харин банкны үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ нь эрс буурсан, итгэх итгэл нь дээшилсэн, банкуудын үйл ажиллагаа түргэн шуурхай болж хувь хүнд хүрч чадаж байна гэж хариулжээ. 2002 оны 10-р сарын 31-ний байдлаар 17 банк үйл ажиллагаа явуулж байгаагийн зэрэгцээ 64 банк бус санхүүгийн байгууллага, мөн хэдэн арван хадгаламж зээлийн хоршоо, ломбардууд санхүүгийн ажиллагаа эрхэлж байна. Энэ нь урд өмнө байгаагүй банк санхүүгийн салбарын өргөн тэлэлт, том үсрэлт юм. Өргөжиж олшрохын зэрэгцээ өрсөлдөөн бий болно. Өрсөлдөөн нь харилцагчдыг хэрхэн татаж яаж үйлчлэхийг сургаж өгнө. Нөгөө талаас банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн харилцагчдаа алдахгүйн тулд аль болох түргэн шуурхай үйлчилгээ явуулж, найдвартай үйл ажиллагаа эрхэлнэ. Энэ бүхний үндсэн дээр харилцагчдын итгэл дээшилж банк санхүүгийн байгууллагаар тогтмол үйлчлүүлнэ. Өнөөгийн байдлаар манай улсад иймэрхүү л үйл явдал өрнөж байна. Харин цаашид үүнийгээ хадгалахын зэрэгцээ улам боловсронгуй болгож бүх нийтийг хамруулах шаардлагатай байна. Ялангуяа иргэдийн эргэлзээ бүрэн арилаагүй (урдын

хямралын сургамж бүрэн мартагдаагүй), зарим иргэд банк санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлж үзээгүй буюу мэдэхгүй ийм үед мэдээлэл, сурталчилгаа, сургалт их үүрэг гүйцэтгэнэ. Иргэдэд мөнгөний хэрэгцээ гарвал хамгийн түрүүнд хувь хүмүүст (найз нөхөд болон дотны хүмүүс) ханддаг, мөн хамгийн амрыг бодож ломбардыг зоридог байдал арилж байгаа нь энэ оны хариултаас харагдаж байна. Судалгаанд оролцсон иргэдийн 50 гаруй хувь нь мөнгөний хэрэгцээ гарвал банк уруу хандана гэж энэ оны санал асуулгад хариулт өгчээ. Хувь хүн, ломбард гэсэн хариултууд багагүй хувийг (14.2-21.6 хувь) эзэлж байгаа ч иргэд маань аль аль талаасаа (зээлдүүлэгч ба зээлдэгч) банкаар үйлчлүүлж эхэлж байгаа нь дээрх хариултаас харагдаж байна. Харин ББСБ, хадгаламж зээлийн хоршоодын талаар тааруухан ойлголттой тул бараг үйлчлүүлдэггүй хэвээр байна. Яваандаа банкуудын хэмжээ томрон үйл ажиллагаа нь өргөжих үед бичил банкны үүргийг дээрх байгууллагууд гүйцэтгэнэ. Иймээс зөвхөн банкууд биш ББСБ, хадгаламж зээлийн хоршоод болон бусад санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сайн сурталчилж, аль болох өргөн хүрээтэй үйлчилгээг олон нийтийн дунд явуулж, санхүүгийн зуучлагчийн үүргээ гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Иргэдийн санал бодлоор манай улсын эдийн засагт дотоодын эх үүсвэрээс гадна гадаадын хөрөнгө оруулалт чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзжээ. Энэ нь эдийн засагт орох хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэн, банк санхүүгийн салбарын өрсөлдөөнийг бий болгож, үйл ажиллагааг нь улам боловсронгуй болгох сайн талтай бөгөөд харин улсынхаа зах зээлийн багтаамж, учруулж болзошгүй эрсдэлийг тооцоолон хэмжээ тоог нь хязгаарлах зөв юм.

Манай улсын иргэдийн бодит орлого бага учир ихэнхэд нь хэмнэх гардаггүй байна. Хэмнэх мөнгөтэй буюу хэмнэх мөнгө байсан тохиолдолд банкинд хадгалуулах, худалдаа наймаа хийж эргэлдүүлэх гэж ихэнх нь хариулсан байна. Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслүүд эрчимтэй нэвтэрч байгаа (ихэвчлэн хүн ам төвлөрсөн газруудад) энэ үед иргэдийн дийлэнх нь мөнгөө бэлнээр байлгах сонирхолтой байгаа нь дээрх хэрэгсэл нь нийт нутаг дэвсгэрийг бүрэн хамарч чадаагүй (үүнд нилээд хугацаа шаардагдана), иргэдийн бодит орлого бага учир ихэнх нь өдрийн амь зугаах хэдэн төгрөгийг бэлнээр авч явдаг, татварын бодлого болон тогтолцооны буруу үйл ажиллагаанаас шалтгаалан татвараас зайлсхийхийн тулд мөнгөө бэлнээр байлгадагтай холбоотой байж болох юм. Мөн нэмж хэлэхэд санхүүгийн зах зээлийн хөгжил дорой тул түүнд хөрөнгөө байршуулах боломжоор тун хомс байдаг нь ажиллагдаж байна. Харин банкинд мөнгөө хадгалуулахдаа төгрөгийг илүүд үзэж байгаа нь төгрөгийн ханшны уналт харьцангуй багасаж тогтворжсон, төгрөгийн хадгаламжийн хүү өндөр, төгрөгийн бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл нэвтэрч эхэлсэн, сүүлийн үед дэлхийн гол валют болох америк долларын ханш харьцангуй тогтвортой биш байгаатай холбоотой болов уу. Хадгаламжийн бодит хүү сүүлийн жилүүдэд эерэг түвшинд байгаа хэдий ч энэ жилийн санал асуулгаар иргэдийн ихэнх нь хадгаламжийн хүүг бага байна гэж хариулжээ.

Сүүлийн үед банк санхүүгийн салбар өргөжин тэлэхийн зэрэгцээ зээлийн хэмжээ, тоо, төрөл нэмэгдсэн хэдий ч иргэдийн хувьд эрэлт нь өндөр хэвээр байна (өнгөрсөн оны түвшинд буюу 80 гаруй хувь). Өнгөрсөн онтой харьцуулахад зээл авахад хүндрэлгүй гэж хариулсан иргэдийн тоо 3 дахин өссөн ч хүндрэлтэй гэж хариулсан иргэд олонхи хэвээр байна. Зээлийн хүүг урьдын адил өндөр байна гэж тэдний ихэнх үзжээ. Мэдээж зээлийг хүссэн хүн болгон авч чадахгүй. Зээл бол тусламж биш. Барьцаа хөрөнгө, бизнес төлөвлөгөө зэрэг эргээд олгосон газарт учруулж болзошгүй эрсдэлээс сэрэмжилсэн олон зүйл шаардагдана. Иймээс иргэдийн зүгээс өөрсдийгөө болон зээл олгож буй байгууллагаа эрсдэл

оруулахгүй байхын төлөө энэ үйл ажиллагаанд оролцох нь хэрэгтэй юм. Хүүний хувьд өндөр байгаатай санал нэг байна. Энэ нь эргээд өөрсдөд (зээл олгож буй байгууллага) нь эрсдэл учруулж болзошгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Цаашид бууруулах тал дээр анхааран ажиллаж байгаа бөгөөд хэмжээ, хугацаа, зориулалтаас хамааран янз бүр байна гэдгийг нэмж хэлэхэд илүүдэхгүй болов уу.

Тайлант оны санал асуулгад шинээр 3 асуулт оруулж бусад гэсэн бүлэгт хамруулан товчхон тайлбарласан болно. Монгол улсын сангийн (төсвийн) бодлогын хэрэгжилтийг судалгаанд оролцсон иргэдийн ихэнх нь муу болон хуучин хэвэндээ байна гэж дүгнэжээ. Түүний зэрэгцээ иргэдийн гуравны нэг орчим хувь энэ талаар ойлголтгүй байна. Сүүлийн жилүүдэд ДБН-д эзлэх төсвийн алдагдлын хэмжээ буурч байгаа хэдий ч татварын ачаалал жил дараалан нэмэгдэж эдийн засгийн өсөлт улмаар иргэдэд хүнд дарамт болж байна. Энэ үед төсвийн реформоо (орлого талдаа ч тэр, зарлага талдаа ч тэр) амжилтай хэрэгжүүлэхгүй юм бол нийгэм, эдийн засгийн тусгамдсан асуудлуудад улам их хүндрэл бэрхшээл учруулах болно анхаарах цаг болсон байна. Гаалийн байгууллагын үйл ажиллагааны хувьд ч иргэдийн зүгээс төсвийн бодлогын нэгэн адил нааштай хариулт өгөөгүй байна. ХАА-н салбарыг орчин үеийн техникжсэн фермерүүдийн хэлбэрт шилжүүлбэл сэргэх боломжтой гэж иргэдийн олонхи үзсэн хэвээр байна. Харин иргэдийн тийм ч бага биш (20.1 хувь) нь эргээд нэгдэл САА-н хэлбэрт арай орчин үеийн түвшинд хөгжүүлбэл уналтаас гарах магадлалтай гэж хариулжээ.

Энэ судалгааны ажил нь хэдий маш товч боловч их өргөн хүрээг хамарснаараа ач холбогдолтой боллоо. Үүний зэрэгцээ Хавсралт I-VI-д иргэдийг харьяалал, хүйс, нас, боловсрол, ажил эрхлэлт, намын гишүүнчлэлийн байдлаар ангилан, бүлэг тус бүрээр нь тайлбар, дүгнэлт хийсэн нь та бүхний сонирхолыг илүүд татна гэдэгт найдаж байна. Дараа дараагийн судалгааны ажлуудаа (санал асуулга) тухайн үеийн тулгамдсан асуудал тус бүрээр нь тусад нь хийж та бүхний сонорт хүргэнэ. Эцэст нь судалгааны ажилд идэвхтэй оролцсон МУИС-ын Социологийн тэнхим, Монголбанкны МБСГ-ын хамт олонд талархсанаа илэрхийлье.